

## ОХУ-ЫН АЗИ ДАХЬ ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГО, СТРАТЕГИ БА МОНГОЛ УЛС

С.Энхцэцэг\*

***Abstract:** This article seeks to examine the geopolitical factors of the Eurasian region in relation to energy resources and transportation. It's been 20 years since the three words Eurasia, energy and Russia have become so interrelated. Russia is regaining its lost position as a great power since the 1990s, when oil and gas prices were high on world markets, and during its rule, it managed to sustainably develop its economy and radically modernize its military strategy and armaments. Rising energy prices in the 2000s revived Russia's neighbors and the world. The resumption of economic sanctions imposed on Russia by Western countries in the wake of the 2014 Ukraine crisis and the establishment of the Eurasian Economic Union in 2015 have been used as an energy strategy.*

***Key words:** Eurasian energy, supra region, energy diplomacy*

\*\*\*

Эрчим хүчний “эзэнт гүрэн” гэгдэх ОХУ дэлхийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээр 4-т, түүхий газрын тосны үйлдвэрлэлээр 3-рт, экспортоор 2-рт, цэвэршүүлсэн газрын тосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр 4-рт, байгалийн хийн 2 дахь том үйлдвэрлэгч, экспортоор тэргүүлэгч улс юм. ОХУ нь байгалийн хийн баталгаат нөөц хамгийн их, түүхий газрын тосны нөөцөөрөө эхний 10-т багтдаг. Цөмийн эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээгээр 3-т, суурилагдсан хүчин чадлаараа 4-рт ордог том гүрэн юм. Дээрх үзүүлэлтүүдээс авч үзэхэд ОХУ-ын түлш, эрчим хүчний цогцолбор нь дэлхийн эрчим хүчний зах зээлийг тодорхойлох хэмжээний далайцтай учраас Оросын тэргүүлэх стратеги эрчим хүчний салбарт төвлөрч гадаад бодлогын хөшүүрэг болжээ.

1995 оны 5 сарын 7-ны өдөр ОХУ-ын анхны ерөнхийлөгч Борис Ельцин ЗХУ-ын үед баримталж байсан эрчим хүчний бодлогод тулгуурлан гаргасан “ОХУ-ын түлш эрчим хүчний үйлдвэрлэл болон эрчим хүчний салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын чиглэл”-ийг баталгаажуулсан бөгөөд улмаар 1995 оны 10 сарын 13-ны өдөр ОХУ-ын засгийн газар “ОХУ-ын эрчим хүчний стратегийн үндсэн заалтууд” хэмээх бодлогын баримт бичгийн чиг баримжаагаар тус салбарыг хөгжүүлэхээ мэдэгдсэн юм. Тус бодлогын баримт бичиг нь ОХУ-ын эрчим хүчний асуудлыг ерөнхий хүрээнд авч үзсэн бөгөөд үүнд дараах асуудлуудыг тусгасан юм. Үүнд:

- Дотоодын эдийн засгийг хөгжүүлэх

\* МУИС-ийн ОУХНУС-ын ОУХ-ны тэнхимийн багш, дэд проф (Ph.D)

- Эрчим хүчний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах
- Төв Ази болон Европ руу чиглэсэн эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлэх
- Эрчим хүчний нөөцийг экспортлох гэсэн ерөнхий чиглэлүүдийг тусгасан юм.<sup>2</sup>

Тус эрчим хүчний стратегийн гол зорилго нь ОХУ-ын нийгэм, эдийн засгийн хөгжлийг сайжруулахад чиглэсэн. Үүнд: 2000-2020 оны хоорон дахь 20 жилийн хугацаанд улс орны болон олон улсын эдийн засгийн үр өгөөж өндөр байх нөхцөл байдалд ДНБ-ний өсөлтийг 3.3 дахин нэмэгдүүлэх, үндсэн хөрөнгө дэх бодит хөрөнгө оруулалтыг тус хугацаанд 7 дахин нэмэгдүүлэх, мөн дэлхийн хамгийн үнэтэй Уралын газрын тосны үнийг 2020 он гэхэд баррель тутамд 30\$ , байгалийн хийн үнийг 1000 см тутамд 138\$-д хүргэх зорилт тавьсан байна. Харин эдийн засгийн нөхцөл байдлыг тухайн үеийн ОХУ-ын болон олон улсын бодит нөхцөл байдалд үнэлэн 2000-2020 оны хооронд эдийн засгийг өсгөх төлөвлөгөөг дараах байдлаар гаргасан байна. Харин эдийн засгийн нөхцөл байдлыг тухайн үеийн ОХУ-ын болон олон улсын бодит нөхцөл байдалд үнэлэн 2000-2020 оны хооронд эдийн засгийг сайжруулах төлөвлөгөөг дээрх байдлаар гаргасан байна<sup>3</sup>. Мөн эрчим хүчний стратегид газрын тосны нийлүүлэлтийн хэмжээг 450-520 метр/тонн хүргэх зорилт тавьсан нь газрын тосны салбарыг хэрхэн чухалчилж авч үзэж байгааг харуулж байгаа юм.<sup>4</sup> Энэхүү бодлогын баримт бичгийн үндсэн зорилтуудыг доор дурдвал:

- Эрчим хүчний нөөцийг экспортлох
- Төрийн өмчит компаниудын гадаад зах зээлийн нөлөөллийг нэмэгдүүлэх
- Эрчим хүч тээвэрлэх
- Түлш эрчим хүчний салбарын олборлолт болон боловсруулалтыг дэмжих
- Эрчим хүчний салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах зэрэг юм.<sup>5</sup>

ОХУ нь түлш, эрчим хүчний салбараараа дамжуулан дэлхийн зах зээлийн интеграцид нэгдэх зорилготой эрчим хүчний дипломат ажиллагаагаар дамжуулан дэлхийн эрчим хүчний салбарт зохих байр сууриа бэхжүүлж, нөлөөллийн хүрээгээ тэлэх зорилго баримт бичигт тусгагдсан байна. Мөн гадаад бодлогын дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Дэлхийн эрчим хүчний зах зээлийн хөгжлийн системийг ОХУ-ын үндэсний ашиг сонирхолтой уялдуулах
- Дэлхийн эрчим хүчний зах зээлд экспорт болон экспортын бүтээгдэхүүний бүтцийг төрөлжүүлэх

<sup>2</sup> Micheal FREDHOLM, the Russian energy strategy and energy policy: Pipeline or mutual dependence? , Conflict studies research centre, Russian series 05/41, 2005, 2-3-р тал

<sup>3</sup> The summary of the Energy Strategy of Russia for the period up to 2020, Ministry of Energy of the Russian Federation, 2003, Moscow, 6-р тал, [http://ec.europa.eu/energy/russia/events/doc/2003\\_strategy\\_2020\\_en.pdf](http://ec.europa.eu/energy/russia/events/doc/2003_strategy_2020_en.pdf)

<sup>4</sup> “Russian Energy Sector – Prospects and Implications for Russian Growth, Economic Policy and Energy Supply”, Tuuli Juurikkala and Simon-Erik OLLUS, 2006, 13-15 –р тал

<sup>5</sup> 9.1. Energy strategy for Russia for the period up to the year 2020, The Russian foreign energy policy, Tugce Varol, European Scientific Institute, July, 2013, 126-р тал, <http://eujournal.org/files/journals/1/books/TugceVarol.pdf>

- Эрчим хүчний зах зээл дэх ОХУ-ын экспортын голлох бүтээгдэхүүний баталгаат эрэлт, үнийн тогтвортой нөхцөлийг бий болгох
- Хилийн чанадад газрын тосны салбарт тэргүүлэх үүрэг бүхий ОХУ-ын төрийн өмчит компаниудын нөхцөл байдлыг сайжруулах
- Олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан газрын тосны салбар дахь томоохон төслүүдийн хэрэгжилтийг хангах<sup>6</sup> талаар тодорхой дурьджээ.

ЗХУ-ын дараа Орос улсад үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, батлан хамгаалахын хэд хэдэн үзэл баримтлал гарсны 2000 оноос хойших нь стратегийн хүрээнд, ялангуяа үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын салбарт түлхүү, цэргийн хүрээнд хязгаарлагдмал хэмжээгээр эрчим хүчийг сонирхож байгаа нь харагдаж байна.

Оросын эрчим хүчний нөөцийг томоохон стратегийн хэрэгсэл, стратегийн том зорилтуудыг хэрэгжүүлэх хэрэгсэл гэж үзэж болно. Эдгээр нөөц нь Оросын гадаад ертөнцтэй харилцах харилцаанд эдгээр нөөцийн гүйцэтгэх үүргээс тодорхой харагдаж байна. Төсвийн орлого бүрдүүлэхээс гадна Оросын эрчим хүчний нөөц нь улс төрийн нөлөөллийн хэрэгсэл болдог. ОХУ-ын эрчим хүчний нөөцийг худалдан авагчидтай эрчим хүчний харилцааг бий болгосноор харилцан хамааралтай байдлыг нэмэгдүүлнэ. Монгол, Оросын эрчим хүчний харилцан хамаарал үүнийг тод харуулж байна.

2014 онд батлагдсан цэргийн номлолд эрчим хүчний талаар хоёр удаа дурдсан байдаг. Эхнийх нь Оросын арми шийдвэрлэх ёстой цөмийн эрчим хүчний байгууламжуудыг хамгаалах хүрээнд, нөгөөх нь чухал дэд бүтэц, түүний дотор эрчим хүчний дэд бүтэцэд заналхийлж байгаатай холбогдуулан үүнийг шийдвэрлэх арга хэрэгсэл гэж тодорхойлжээ. 2015 оны Үндэсний аюулгүй байдлын стратеги нь эрчим хүчний аюулгүй байдлын асуудалд онцгой анхаарал хандуулж, эрчим хүчний талаар 24 удаа дурьдахдаа эрчим хүчний зах зээлийн тогтворгүй байдал, түлш, эрчим хүчний салбарт төр, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, цэрэг, хоол хүнс, мэдээлэл, эрчим хүчний аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг Оросын үйлдвэрлэгчдийн төрийн хамгаалалт зэргийг онцгойлон авч үзжээ. Эрчим хүчний аюулгүй байдлыг “Эдийн засгийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг урт хугацаанд хангах үндсэн арга замуудын нэг” гэж тодорхойлжээ.

2016 оны гадаад бодлогын үзэл баримтлалд эрчим хүчний талаар 12 удаа дурьдсан байдаг. Ингэхдээ олон улсын харилцааны системийн өөрчлөлт, хувьслын хүрээнд эрчим хүчтэй холбоотой асуултуудыг тавьж, нөхөн сэргээгдэх боломжгүй нүүрсустөрөгчийн нөөцийг олборлох шинэ технологийг нэвтрүүлснээс үүдэн гарч буй эрчим хүчний салбарын чанарын өөрчлөлтөд онцгой анхаарал хандуулсан байна. Энэхүү стратегийн баримт бичигт “улс орнууд эрчим хүчний

<sup>6</sup> Energy strategy of Russia for the period up to 2030, approved by decree №1715-r of the Government of the Russian Federation dated 13 November 2009, Moscow 2010, Ministry of Energy of the Russian Federation, Institute of Energy strategy, PAC Energiya, 7. Innovation and scientific-and-technical policy in the energy sector, 55-57-р тал, [http://www.energystrategy.ru/projects/docs/ES-2030\\_\(Eng\).pdf](http://www.energystrategy.ru/projects/docs/ES-2030_(Eng).pdf)

аюулгүй байдлаа хангахын тулд дэлхийн зах зээл дээрх оролцоогоо төрөлжүүлэх шаардлагатай байгаа” нөхцөлд эрчим хүчний салбарт “үндэслэлгүй хязгаарлалт болон бусад ялгаварлан гадуурхах арга хэмжээ авах” тухай асуудлыг тусгасан болно. Эрчим хүчний аюулгүй байдал, цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах олон талт хамтын ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ дээрх хандлагыг анхаарч үзэх хэрэгтэй бөгөөд “Орос улс эрчим хүчний тэргүүлэгч үйлдвэрлэгчидтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж, тогтвортой эрэлт, хэрэгцээтэй хэрэглэгч болон дамжин өнгөрөх орнуудтай тэгш яриа хэлцлийг дэмжиж байна. Үүнээс гадна уг баримт бичигт ЕХ -ийг “эрчим хүч, түүний дотор худалдаа, эдийн засаг, гадаад бодлогын чухал түнш” гэж тодорхойлжээ.

Эрчим хүчний стратегийн асуудлыг зөвхөн үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, гадаад бодлогын тухай Оросын сургаалд хэлэлцээд зогсохгүй Оросын эрчим хүчний стратеги баримт бичгийн хүрээнд илүү дэлгэрэнгүй авч үзсэн байдаг. ЗХУ-ын дараа ийм бодлого тусгагдсан Оросын 7 албан ёсны баримт бичгийг нийтлэсэн байдаг. Зураг 1-аас үзнэ үү).

Зураг 1



Эдгээр баримт бичигт ОХУ-ын эрчим хүчний салбарын богино, дунд, урт хугацааны зорилтуудыг тусгахдаа хүрэх арга зам, амжилтанд хүрэхийн тулд салбарын шийдвэрлэх ёстой бэрхшээлүүдийг үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын хүрээнд авч үзэж, стратегийн ач холбогдлын талаар зарим санааг тусгасан нь чухал ач холбогдолтой юм.

2019 оны ОХУ -ын эрчим хүчний аюулгүй байдлын үзэл баримтлалд эрчим хүчний аюулгүй байдлыг хангах тухай албан ёсны байр суурийг тусгасан. Эрчим хүчний аюулгүй байдал, аюул занал, сорилт, эрсдэл гэх мэт үндсэн ойлголтуудыг тодорхойлохоос эхэлдэг. Дэлхийн нөхцөлд хамааралтай хэвээр үлдэж, дотоодын хэрэглэгчдээ эрчим хүчээр хангах боломжтой байхын тулд тус улсын эрчим хүчний салбар шийдвэрлэх ёстой зарим сорилт, аюул, эрсдэлийг тодорхойлжээ. Эдгээр

чухал асуудлууд нь Оросын эрчим хүчний компаниудын орчин үеийн технологид нэвтрэх эрхийг хязгаарласан хориг арга хэмжээ, урт хугацааны санхүүжилт, Оросын эрчим хүчний оролцогчдыг ялгаварлан гадуурхсан гэж үзэж буй бусад орнуудын хамтарсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх; олон улсын уур амьсгалын бодлого, эрчим хүчний уламжлалт эх үүсвэрийн дэлхийн хэрэглээг бууруулж болзошгүй ногоон эрчим хүчний шилжилтийг хурдасгах бодлого нүүрсустөрөгчийн нөөц нэмэгдэж, ОХУ-ын эрчим хүчний чухал нийлүүлэгч болох хангалттай дэд бүтэц байхгүй Ази, Номхон далайн бүс нутаг руу шилжиж буй энэ нөхцөлд онцгой хүндрэлтэй байна.

Түүнчлэн дэлхийн шингэрүүлсэн байгалийн хийн (LNG) зах зээл болон шинэ хий нийлүүлэгчид /АНУ-ын шатдаг занарын экспорт/ гарч ирсэн нь Оросын эрчим хүчний аюулгүй байдалд заналхийлж байна гэж үзжээ. Цаашилбал, Оросын эрчим хүчний салбарт ялангуяа ЕХ-той харилцах харилцаанд хууль эрх зүйн болон зохицуулалтын хэд хэдэн бэрхшээл тулгардаг бол дотооддоо энэ салбар нь чанар муутай нөөц, авлига, ирээдүйн эрэлт хэрэгцээний тодорхойгүй байдал зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна. Байгаль орчны хэт их дүрэм журмын улмаас үүссэн саад бэрхшээл ОХУ-д их байна<sup>7</sup> гэж дүгнэжээ.

ОХУ-ын судлаач Наталиа Викторовна Кузнецова 2000, 2009, 2014 онуудад батлагдсан эрчим хүчний стратегийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийгээд ОХУ-ын эрчим хүчний стратегийн баримт бичгүүд бүгд Ази руу чиглэсэн бөгөөд мөн үүнтэй холбогдуулан дотоодын бүс нутгуудыг хөгжүүлэх асуудал дээр төвлөрч ажиллаж байгааг онцолсон юм. Мөн ОХУ-ын Ази-Номхон далайд чиглэсэн эрчим хүчний бодлого нь цэвэр геополитикийн шинж чанартай хэмээн дурьдсан бөгөөд улмаар тус бүс нутгаар дамжуулан үндэсний ашиг сонирхлоо хэрэгжүүлж, үндэсний аюулгүй байдлынхаа баталгааг бий болгоход чиглэсэн хэмээн дүгнэсэн юм.<sup>8</sup> ОХУ-ын газрын тосны бодлогын чиглэлээр цогц судалгааг хийсэн судлаач Тугче Варол ОХУ нь дотоодын хөгжлөө зүүн бүс рүүгээ шилжүүлж байгаа төдийгүй гадаад бодлогын чиглэлийг Ази, тэр дундаа ЗХА-руу чиглүүлж байна хэмээн дүгнэсэн юм. Улмаар цэргийн номлол, гадаад бодлогын үзэл баримтлал, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтайг сайн уялдаж өгсөн хэмээн онцолжээ. ОХУ-ын газрын тосны бодлого цэвэр геополиткийн шинж чанартай бөгөөд үндсэн зорилго нь үндэсний аюулгүй байдлаа хангах явдал<sup>9</sup> юм хэмээн дүгнэсэн байдаг.

Судлаач С.Эгмонд, Р.Жонкерс, Г.Кок нарын үзсэнээр<sup>10</sup> эрчим хүчний бодлоготой холбоотой арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэхдээ шүүх-хууль эрх зүй, эдийн засаг, харилцаа холбоо, дэд бүтэц гэсэн 4 үндсэн хэрэгслийг ашиглаж эрчим хүчний

<sup>7</sup> Vladimir Kutcherov, Maria Morgunova, Valery Bessel, and Alexey Lopatin, "Russian natural gas exports: An analysis of challenges and opportunities. Energy Strategy Reviews 30 (2020) 100511, p.4

<sup>8</sup> Energy Strategy of the Russian Federation, Natalia Victorovna Kuznetsova, Doctor of Economics, professor, Department of World Economy, Vol 6 No 5 September 2015

<sup>9</sup> The Russian foreign energy policy, Tugce Varol, European Scientific Institute, July, 2013, 125-126 тал, <http://ejournal.org/files/journals/1/books/TugceVarol.pdf>

<sup>10</sup>

салбарт оролцогчдын зан төлөв, тогтоосон хэм хэмжээнд нөлөөлөхийг оролддог хэмээн үзжээ. Хэрэв оролцогчид үүнийг дагаж мөрдвөл шагнал хүлээнэ, хэрэв тэд дүрмээр тоглоогүй бол ямар нэгэн шийтгэл хүлээж магадгүй. Шүүхийн эрх зүйн эдгээр олон арга хэрэгслийг Оросын нөхцөлд ашигласан гэж дүгнэсэн байна. Тухайлбал, 2010 онд байгуулсан гэрээгээр Украинд ОХУ-ын стратегийн бодлогыг дэмжсэний хариу болгон байгалийн хийн тусгай үнийг санал болгосон гэж үзжээ. Стокгольмын арбитрын шүүх Орос-Украины хийн харилцааны бүх асуудлыг шийдвэрлэсэн нь хууль эрх зүйн хэрэгслийг хоёр тал эрчим хүчний хүрээнд хэрхэн ашиглаж болохыг харуулж байна. Янз бүрийн хэлбэрээр хууль эрх зүйн хэрэгслийг ашиглах нь олон төрлийн эрчим хүчний тоглогчидтой хийх Оросын харилцаанд тод харагддаг.

### Хүснэгт 1

#### ОУХ-ын эрчим хүчний стратеги бодлогыг хэрэгжүүлэх алхам

Арга хэрэгсэл	Хууль, эрх зүйн	Эдийн засгийн	Харилцах механизм	Бүтцэд хамаарах
Татаас		х		
Хий дамжуулах хоолойн хаалт		х	х	Х
Дамжуулах хоолойн дэлбэрэлт		х	х	Х
Дамжин өнгөрөх дамжуулах хоолойн өөр хувилбар барих	х	х		Х
Халаасан риторик			х	
Импортын хориг саад		х	х	Х
Цахим халдлага		х	х	Х
Хувийн харилцаа, хэлхээ холбоо			х	
Нарийвчилсан PR кампанит ажил			х	
Шүүхийн хэрэг	х			
Цэргийн оролцоо			х	Х

Хууль эрх зүйн арга хэрэгслийг ихэвчлэн санхүүгийн асуудалд нөлөөлөх, Оросын ашиг сонирхолд нийцсэн хүмүүст эдийн засгийн урамшуулал өгөх, Оросын төлөвлөгөөг эсэргүүцэж буй хүмүүсийг урамшуулахгүй байх зорилготой эдийн засгийн хэрэгслүүдтэй хослуулдаг. ЕХ-ны Комиссын анхаарлыг татсан Газпромын үнийн бодлого нь Оросын тоглогчид энэ төрлийн хэрэгслийг ашиглахыг онцлон харуулсан бөгөөд Орос Беларусь болон бусад Зөвлөлтийн нөлөөнд байсан орнуудад давуу эрх олгосон гэх мэт олон жишээ бий. Мэдээлэл өгөх, ятгах, үнэмшүүлэх, уруу татах зорилгоор мэдээлэл дамжуулдаг харилцааны хэрэгслийг Оросын стратегийн болон эрчим хүчний ашиг сонирхлын үүднээс ихэвчлэн ашигладаг. Эдгээр хэрэгслийг бусад төрлийн хэрэгслүүдтэй хослуулж, дэмжих замаар олон нийтийн санаа бодолд нөлөөлөх, нийгмийн дэмжлэг үзүүлэх эсвэл мэдлэгийг дээшлүүлэхэд ихэвчлэн ашигладаг байна. Нөгөө талаас стратегийн харилцан хамаарал бүхий эрчим хүчний бодлогыг стратегийн том зорилтуудыг хэрэгжүүлэх хэрэгсэл болгон бүх ашиглах, цэргийн хүчийг эрчим хүчний бодлогын параметруудийг өөрчлөхөд ашиглах эрх зүйн орчин нээлттэй байгаа юм.

Оросын стратегийн баримт бичгүүдийг авч үзэхэд Оросын бодлого боловсруулагчид тус улсын эрчим хүчний нөөцийн ач холбогдлыг гүнзгий ухамсарласан байдал ажиглагддаг. Эдгээр нөөцийг хөгжүүлэх, хамгаалах хоёр чухал шалтгаан байгаа тул улс орны үндэсний стратегийн чухал зорилт гэж үздэг. **Нэгд**, Оросын эрчим хүчний нөөц хүн ам, дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг боломжийн үнэтэй, найдвартай эрчим хүчээр хангадаг. **Хоёрт**, өнөөгийн нийгмийн тогтолцооны тогтвортой байдал, тусгаар тогтнолыг баталгаажуулж дэлхийд Оросын эдийн засгийн өрсөлдөх чадварын баталгаа гэж үздэг.

Дотоодын хэрэглэгчид болон гадаад түншүүдээ эрчим хүчээр хангахын тулд Орос энэ салбарт тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж, шийдвэрлэх үүднээс эрчим хүчний салбарын ашиглалтын хугацааг уртасгах, одоогийн болон ирээдүйн аюул занал, сорилт, эрсдэлийг даван туулах чадвараа сайтар бэлтгэх нь Оросын эрчим хүчний бодлогын гол зорилтын нэг юм. ОХУ -ын Эрчим хүчний яамнаас гаргасан 2019 оны баримт бичигт<sup>11</sup> Оросын эрчим хүчний бодлогын ойрын жилүүдэд хэрэгжүүлэх 4 үндсэн зорилтыг тусгажээ.

1. Эрчим хүчний гадаад харилцагчидтай хийсэн гэрээний биелэлт, үр ашигтай байдалд анхаарах;
2. Байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөллийг бууруулах, инновацийн түвшинг дээшлүүлэх замаар Оросын эрчим хүчний салбарын байгаль орчны үр ашгийг нэмэгдүүлэх;
3. Дулаан хангамжийн үнэ тогтоохтой холбоотой асуудалд хандах хандлагыг өөрчилж, дулаан хангамжийн зах зээлийг бүрдүүлэх;
4. Оросын эрчим хүчний салбарт дэвшилтэт болон дижитал технологийг нэвтрүүлэх. Эдгээр зорилтуудыг шаардлагатай санхүүжилт, технологи нийлүүлэгч, эсвэл зах зээлд нэвтрэх үйлчилгээ үзүүлэгчийн хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг бусад компаниудтай хамтран хэрэгжүүлэх бөгөөд ингэснээр компаниуд болон улсын аль алинд нь орлого бүрдэх боломжийг сайжруулах. Эдгээр нь гадаад эрчим хүчний цогц стратегитэй байх нь яагаад чухал болохыг тайлбарлаж байна.

2035 он хүртэлх Оросын эрчим хүчний стратегийн ойрын жилүүдэд хэрэгжүүлэх 4 үндсэн стратегийг тодорхойлсон. **Нэгдүгээрт**, Оросын эрчим хүчний нөөцийн хуучин болон шинэ хэрэглэгчидтэй тогтвортой харилцаа тогтоох, хадгалах, дэлхийн эрчим хүчний зах зээлд Оросын хувьцааг баталгаажуулах; **хоёрдугаарт**, бүтээгдэхүүний багцын хувьд экспортын төрөлжилтийг нэмэгдүүлэх, боловсруулсан бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх; **гуравдугаарт**, ОХУ-ыг хийн дамжуулах хоолойн чухал тоглогч болгох; **дөрөвдүгээрт**, Оросын эрчим хүчний компаниуд болон тэдний гадаад түншүүдийн хамтын ажиллагааны түвшинг дээшлүүлэх хэмээн үзжээ.

Дэлхийн олон туйлт системийн хүрээнд өрнөдийн нөлөөг бууруулдаг Азийн

<sup>11</sup> N.Alexeev et al., "A Critical Review of Russia's Energy Strategy in the Period until 2035." International Journal of Energy Economics and Policy., 2019, 9 (6), 95-102 p.96

орнуудтай стратегийн түншлэл байгуулснаар эрчим хүчний нөөц нь Оросын их гүрний стратегид чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Азийн орнуудтай эрчим хүчний хэд хэдэн гэрээ, түншлэлийн гэрээ байгуулж, хэрэгжүүлээд байна. Ази руу чиглэсэн бодлогын өөрчлөлт нь 2014 оны Украины хямралын дараа улам хүчээ авч, барууны нөлөө, зах зээлийн хараат байдлыг тэнцвэржүүлэх стратегийн нэг чухал хэсэг юм. Ази тивд үйл ажиллагаа явуулахдаа Орос өөр өөр түвшинд стратегийн ач холбогдолтой бүлэг орнуудтай харилцах боломжтой болсон. Ю.Примаков ОХУ-ын Гадаад хэргийн сайдаар ажиллаж байх хугацаандаа Хятад, Энэтхэгийг дэлхийн олон туйлт орчныг бүрдүүлэх хамгийн чухал түншүүдээр тодруулж байсан бөгөөд эдгээр улс хоёулаа Оросын зэвсгийн чухал худалдан авагчид гэж тооцогддог.

Хятад бол барууны дэлхийн нөлөөг хязгаарлах талаасаа ч, Оросын эрчим хүчний хамгийн ирээдүйтэй зах зээлийн хувьд ч Азийн хамгийн чухал стратегийн түнш юм. Энэхүү эрчим хүч, улс төрийн түншлэлийн цаашдын хөгжлийг хязгаарлаж буй газарзүйн болон тогтолцооны хязгаарлалтууд бий. Эдийн засгийн чухал түнш, технологийн гол нийлүүлэгч Өмнөд Солонгос Азийн эрчим хүчний зах зээлд Оросын нөлөөг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. ОХУ-ын Хойд туйлын байгалийн хийн (LNG) терминалуудад үйлчлэх мөсөн ангиллын танкеруудын флотыг байгуулахад Өмнөд Солонгосын усан онгоцны үйлдвэрүүд оролцож байгаа юм. Аюулгүй байдлын талаасаа Оросын Хойд Солонгост хандах хандлага Өмнөд Солонгостой харилцах харилцаанд нөлөөлж болзошгүй юм.

Энх тайвны гэрээний асуудал, Курилын арлуудын нөхцөл байдал гэх мэт шийдвэрлэх шаардлагатай эмзэг асуудлууд бий ч Япон нь Ази дахь Оросын эрчим хүчний ашиг сонирхолд өндөр байр эзэлдэг бөгөөд Оросын хий, газрын тосны чухал зах зээл болжээ. Япон улс АНУ-ыг Азид байлгахыг тууштай дэмжигч, Ази дахь барууны стратегийн гарц гэж үздэг. ОХУ болон Япон улсын хооронд Арктикийн бүс нутагт хамтран ажиллах сонирхол геополитикийн ашиг сонирхол юм. Нэг талаас ОХУ Япон улстай эдийн засаг, эрчим хүчний салбарт илүү ойр хамтран ажиллаж шинжлэх ухаан, технологийн инновацийг өөрийн орондоо хөгжүүлэх, мөн Япон руу эрчим хүч тэр дундаа газрын тос, байгалийн хий экспортолж геоэдийн засаг, геополитикийн нөлөөллийн хүрээгээ тэлэх, харилцан хамаарал бий болгох ашиг сонирхол байгаа юм. Япон улсын хувьд тус бүс нутагт хамаарах хойд далайн зам нэн чухалд тооцогдож байгаа юм. Учир нь Атлантын далайгаас, Номхон далай хүртэлх хамгийн дөт зам бөгөөд энэ нь Сибирийн хойд эргээр дайрч өнгөрдөг юм. Энэ зам Япон улсын хувьд Ойрхи Дорнодоос эрчим хүч импортлох өөр нэг зам болж байгаа бөгөөд Малакк, Ормузын хоолойгоос хэт хамааралтай байдлыг багасгах юм.<sup>12</sup> ОХУ-ын Ерөнхий сайд Д. Медведев тус замын хүчин чадлыг 15 жилийн хугацаанд 4 сая тонноос 80 сая тонн болгож нэмэгдүүлнэ<sup>13</sup> хэмээсэн тул Япон улсад энэхүү бүтээн байгуулалт нь стратегийн түвшинд хамтран

<sup>12</sup> How Japan and Russia Cooperate in the Arctic., <http://thediplomat.com/2016/03/how-japan-and-russia-cooperate-in-the-arctic/>

<sup>13</sup> Medvedev orders plan to increase Northern Sea Route capacity <http://barentsobserver.com/en/arctic/2015/06/medvedev-orders-plan-increase-northern-sea-route-capacity-10-06>



ажиллах сонирхолыг нэмэгдүүлж байгаа юм. Япон нь ОХУ-ын Арктикийн бүс дэх аж үйлдвэрийн томоохон цогцолбор болох 27 тэрбум долларын өртөг бүхий Ямалын шингэрүүлсэн байгалийн хийн төсөлд хамтран ажиллах сонирхол байгаа юм. Тухайлбал, Токиод зохиогдсон ОХУ-Японы худалдаа, үйлдвэрийн яриа хэлэлцээр дээр Новатекийн удирдах зөвлөлийн дарга Денис Храмов тус асуудлын талаар хөндсөн бөгөөд Арктикийн бүс нутгийн шингэрүүлсэн хийн төсөлд Япон улс оролцох талаар мөн дурдсан юм. Бүс нутгийн томоохон эрчим хүчний төсөлд хоёр улс хамтран ажиллах нь ОХУ-Японы цаашдын хамтын ажиллагаанд дэвшил гаргах<sup>14</sup> боломжтой. ОХУ Японтой хамтын ажиллагаагаа өргөжүүлж, харилцан хамаарлаа нэмэгдүүлэх гэсэн бодит алхмууд хэрэгжүүлж буй нь ЗХА дахь газрын тосны дипломат ажиллагааны илрэл юм.

Азийн түншүүд нь ОХУ-ын эрчим хүчний салбарын үйл ажиллагааг дэмжиж, дэлхийд өрсөлдөх чадвартай болгоход чухал үүрэг гүйцэтгэж байна. Ялангуяа томоохон дэд бүтцийн төслүүдийг хамтран санхүүжүүлэх, эсвэл технологийн чухал шийдлүүдийг олж авах боломжийг бүрдүүлж байна. Азийн зах зээлд нийлүүлэх боломжоо нэмэгдүүлэхийн тулд Орос шинэ хийн болон газрын тосны ордыг нээх, ашиглах шаардлага үүсч байна. Тиймээс Азийн түншүүддээ томоохон төслүүдэд санхүүгийн хөрөнгө оруулагчаар хамтран оролцох боломжийг олгож байна. Европын эрчим хүчний зах зээлээс ялгаатай нь Азийн эрчим хүчний зах зээл шинэ өсөх ирээдүйтэй юм. Түүгээр зогсохгүй Европын орнуудаас ялгаатай нь Азийн орнууд эрчим хүчний бодлогоо боловсруулж, хэрэгжүүлэхдээ уур амьсгалын асуудалд өртөх магадлал багатай. Шинэ талбарыг хөгжүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулалт, шинэ технологид нэвтрэх шаардлагатай тул Азийн өсөн нэмэгдэж буй эрчим хүчний зах зээлд дунд болон урт хугацааны нийлүүлэлтийг хангах нь Оросын эрчим хүчний салбарын ирээдүйг баталгаажуулах, барууныхны шахалтанд өртөхгүй байх, цаашдын хамтын ажиллагаа, нөлөөллийг хангахад чухал ач холбогдолтой юм.

### **ОХУ-ын байгалийн хийн бодлого, стратеги:**

ОХУ-ын БНХАУ-тай түлш, эрчим хүчний салбарт идэвхтэй харилцаж буй энэхүү байдлаа гадаад бодлогын үзэл баримтлалд дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал: тус үзэл баримтлалын 79 дүгээр зүйлд “ОХУ-ын гадаад бодлогод БНХАУ, Энэтхэг улстай найрсаг харилцааг хөгжүүлэх нь тэргүүлэх зорилтуудын нэг юм”, мөн 80 дугаар зүйлд “ОХУ нь БНХАУ-тай иж бүрэн, тэнцвэртэй, найдвартай нөхөрлөл, стратегийн хамтын ажиллагааг бий болгож хамтын ажиллагааны бүхий л хүрээнд идэвхтэй хамтран ажиллана”<sup>15</sup> хэмээн тусгасан байна. ОХУ-ын хувьд

<sup>14</sup> Russia's largest independent gas producer ready to cooperate with Japanese companies., <http://tass.ru/en/economy/859556>

<sup>15</sup> Concept of the Foreign Policy of the Russian Federation, Approved by President of the Russian Federation V. Putin, on 12 February 2013, 303-18-02-2013, IV. Regional Prioritiescccc, 16-p тал, <http://archive.mid.ru/bdomp/ns-osndoc.nsf/1e5f0de28fe77fdcc32575d900298676/869c9d2b87ad8014c32575d9002b1c38!OpenDocument>

тус зүйл заалтууд нь асар хурдацтай өргөжин тэлж буй ОХУ-БНХАУ хоорондын эдийн засаг, эрчим хүчний салбар дахь найрсаг хамтын ажиллагааны үндэс болж байгаа юм.

ОХУ нь өөрийн орны экспортын гуравны хоёрыг дангаараа бүрдүүлдэг түлш эрчим хүчний салбарт Ази тэр дундаа ЗХА руу чиглэсэн дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн бөгөөд үүнд БНХАУ-тай идэвхтэй хамтран ажиллаж байгаа юм<sup>16</sup>. Тухайлбал: БНХАУ-ын дарга Си Зинь Пин ОХУ-ын ерөнхийлөгч В. Путины урилгаар 2015 оны айлчлалын хүрээнд хоёр орны геополитик, худалдаа, санхүү болон бусад олон салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 30 гаруй гэрээнд гарын үсэг зурсан түүхтэй. Үүнээс нэн чухалд тооцогдох нь “Газпром”, “Синопек” компани хооронд 2015 онд 30 тэр бум куб.м байгалийн хийг нийлүүлэх хоолой барих “Сибирийн хүч” төсөлд гарын үсэг зурсан юм.<sup>17</sup> Энэ нь нэг талаараа БНХАУ-д нийлүүлэх байгалийн хийн асуудалд бие даасан байдлаа хамгаалж, давуу байдлаа хадгалах гэсэн нөгөө талаараа бусад Ази-Номхон далайн орнууд руу нийлүүлэх гэсэн газар зүйн байршилтай хийн хоолой болж байгаа юм. Энэхүү Ази руу чиглэсэн ОХУ-ын түлш, эрчим хүчний дипломат ажиллагаа нь нэг талаараа ЗХА-д нөлөөллөө тогтоож, түлш, эрчим хүчний худалдааны асар том зах зээлд нөлөө бүхий тоглогчийн байр сууриа улам бэхжүүлж буй хэдий ч нөгөө талаараа Зүүн Сибирь, Алс Дорнод зэрэг стратегийн бүс нутгуудыг хөгжүүлж дотоодын эдийн засаг, эрчим хүчний аюулгүй байдлыг хангах эдийн засгийн агуулгатай стратегийн зорилготой том төсөл юм.

Алс Дорнодын бүс нутгийг эрчим хүчний хувьд нэн яаралтай хөгжүүлэх асуудлыг “2030 он хүртэл баримтлах ОХУ-ын эрчим хүчний стратеги”-ийн баримт бичгийн хөгжлийн 2-р үе шат болох “2013-2015, 2020-2022 онуудын хооронд Зүүн Сибирь, Алс Дорнод, Ямалын хойгийг хөгжүүлэх” асуудал дээр тусгаж өгсөн<sup>18</sup>. 2013-2015 оны хооронд хийгдэж үйл ажиллагаа 2020-2022 оны хооронд эхлэх юм. ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путин “Байгалийн хийн экспортлогч орнуудын чуулга уулзалт”-д Ази руу чиглэсэн хийн хангамжийг 6-аас 30 хувь хүртэл буюу жилд 120 тэрбум куб.м хүргэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдсэн. Үүний дотор шингэрүүлсэн байгалийн хийг 60 сая тоннд буюу 13<sup>19</sup> хувьд хүргэхээр төлөвлөжээ. Энэ нь 2035 он хүртэл ОХУ-ын эрчим хүчний салбарт баримтлах стратегийн төсөлд тусгагдсан бөгөөд 2035 он гэхэд байгалийн хийн олборлолтыг 40 хувиар нэмэгдүүлж 885 тэрбум куб.м хүргэх зорилт тавьсан юм.<sup>20</sup> Мөн ОХУ-ын ЗХА-ын орнуудтай эрчим хүчний салбарт харилцаа сайжрахын сацуу дотоодын газрын тосны бүтээгдэхүүн, байгалийн хийн үйлдвэрлэл нэмэгдэхийн хэрээр экспортын хэмжээ өсөх нь

<sup>16</sup> Мөн 14-р тал, Олон улсын байдал ба Монгол улс 2015 онд

<sup>17</sup> <http://www.gmfus.org/publications/turkey-and-russias-proxy-war-and-kurds>

<sup>18</sup> Energy strategy of Russia for the period up to 2030, approved by decree №1715-r of the Government of the Russian Federation dated 13 November 2009, Moscow 2010, Ministry of Energy of the Russian Federation, Institute of Energy strategy, PAC Energiya, 17-19-р тал, [http://www.energystrategy.ru/projects/docs/ES-2030\\_\(Eng\).pdf](http://www.energystrategy.ru/projects/docs/ES-2030_(Eng).pdf)

<sup>19</sup> <http://en.kremlin.ru/events/president/news/50755>

<sup>20</sup> Энергетическая стратегия России на период до 2035 года, проект утверждена распоряжением Правительства Российской Федерации, 23-р тал [http://www.energystrategy.ru/ab\\_ins/source/ES-2035\\_09\\_2015.pdf](http://www.energystrategy.ru/ab_ins/source/ES-2035_09_2015.pdf)

дамжиггүй. Улмаар ЗХА цаашлаад Ази номхон далайн бүс нутаг дахь ОХУ-ын нөлөөллийг улам бэхжүүлж өгөх юм.

Орос улс АНУ -ын дараа дэлхийн хоёр дахь том байгалийн хий үйлдвэрлэгч бөгөөд Иран, Канад, Катарын дараа ордог. Сүүлийн жилүүдэд дэлхийн байгалийн хий олборлолт 3868 тэрбум шоо метр (рекорд) рекорд тогтоож, 2018 онд ОХУ -ын 669 тэрбум шоо метр болсон байна. ОХУ -д байгалийн хийн асар их нөөц байгаа нь дотоодын зах зээлийн нөхцөл байдлаас үл хамааран хийн экспортыг нэмэгдүүлэх боломжийг олгодог. ОХУ -ын нийт байгалийн хийн үйлдвэрлэлийн 30 гаруй хувийг экспортолдог. Байгалийн хийн экспорт нь дамжуулах хоолойн системээр дамжин хийгээр хийгддэг. Оросын байгалийн хийн (LNG -ийн) экспортын газарзүйд Ази номхон далайн орнууд (Япон, Өмнөд Солонгос, Тайван), Европ болон бусад орнууд (Ойрхи Дорнод, Канад зэрэг бага хэмжээгээр орно), дамжуулах хоолойн хувьд Европ, ТУХН -ийн орнууд голчлон ордог.

ЗХУ-ын үе шатанд дамжуулах хоолой, насосны станцууд болон бусад холбогдох дэд бүтцийг багтаасан байгалийн хий экспортлох асар том системийг бий болгосон бөгөөд энэ нь голчлон Европын хэрэглэгчдэд зориулагдсан байв. Хөгжсөн дэд бүтцийн хүчин чадал нь ТУХН -ийн орнууд 2, Европ руу байгалийн хий тогтмол нийлүүлэх боломжийг хангаж өгдөг ч дамжуулах хоолойн систем нь уян хатан биш, тодорхой зах зээл эсвэл хэрэглэгчидтэй холбоотой байдаг.

Ази тивийн эрчим хүчний худалдаанаас ОХУ-ын олох орлого нэмэгдэж байгаа ч Сибирийн эрчим хүч дамжуулах хоолойн дэд бүтэц бүрдүүлэх Сахалин I, Сахалин II төслүүдэд харьцангуй өндөр өртөгтэй хөрөнгө оруулалт хийгдсэн гэж үздэг байна. ОХУ -ын байгалийн хийн экспортын чадавхийг хөгжүүлэхэд ирээдүйн байгалийн хийн (LNG) төслүүд ихээхэн нөлөөлнө (Хүснэгт 2).

## Хүснэгт 2.

### ОХУ-ын Ази дахь эрчим хүчний томоохон төслүүд

Төсөл	Байршил	Хүчин чадал (сая, тн)	Хувь эзэмшигчид	Өнөөгийн байдал
Яамал (LNG)	Сабетта, Яамалын арал	16.5	Новатек (Russia)-50.1 Тотал (France) – 20% CNPC (China) – 20% Silk Way Fond (China) – 9.9%	Үйл ажиллагаа эхлүүлсэн
Сахалин 2	Анива тойрог, Сахалины арлууд	10	Газпром – 50% +1 share Шелл – 27.5%-1 share Мицуй (Japan) – 12.5% Мицуйбиши (Japan) – 12.5%	Үйл ажиллагаа эхлүүлсэн

Арктик (LNG 2) Алс Дорнод (LNG)	Gydan Peninsula De-Kastri, Хабаровск	18.3 6.2	Новатек (Russia) – 100% Роснефть (Russia) – 20% Еххон Mobil- 30% Содеко (Japan) – 30%	Төлөвлөсөн
Балтик (LNG)	Уст-Луга, Ленинградын бүс	10-15	ONGC (India) – 20% Хамтарсан төсөл /Газпром, Шелл хамтарсан/	Төлөвлөсөн


Хүснэгт 2-т дурьдсан бүх төслүүд хэрэгжих тохиолдолд Оросын экспортын боломж 65 сая тонн (96 тэрбум шоо метр) хүрэх ажээ. Шинэ терминал барьж байгаа хэдий ч Орост далайгаар урт хугацаанд экспортлох байгалийн хийн (LNG-ийн) дэд бүтэц хязгаарлагдмал төдийгүй худалдааг өргөжүүлэх өөр нэг хязгаарлалт бол ажиллахад бэлэн LNG танкер байхгүй байгаа явдал юм. 2015-2017 онуудад ОХУ-ын газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэл нь холбооны төсвийн орлогын 40 хүртэл хувийг бүрдүүлдэг байсан бол 2018 онд 46% -иас дээш хэмжээнд хүрсэн байна. Экспортын эзлэх хувь хэмжээг хадгалах, экспортын чиглэлийг төрөлжүүлэх (дамжуулах хоолойн хий, LNG аль аль нь) нь Оросын засгийн газар болон эрчим хүчний компаниудын өмнө тулгарч буй гол бэрхшээл юм.

ОХУ -ын 2020 он хүртэлх эрчим хүчний стратеги (2003 онд батлагдсан) нь ТУХН -ийн орнууд болон Европын зах зээлд чиглэсэн бөгөөд голчлон хойд, зүүн, өмнөд чиглэлд экспортын замыг төрөлжүүлэхэд чиглэсэн байв. Ази, Номхон далайн болон АНУ-ын зах зээлийг байгалийн хий (LNG) экспортлох ирээдүйтэй гэж үздэг. ОХУ-ын 2030 он хүртэлх эрчим хүчний стратеги (2009 онд хүчин төгөлдөр болсон) бодлогод ихээхэн өөрчлөлт оруулсан боловч хийн экспортыг урт хугацааны гэрээнд үндэслэн үргэлжлүүлнэ гэж үзсэн. Европын зах зээлд нийлүүлэх экспортын хэмжээг хадгалах, Азийн (Хятад, Япон, Өмнөд Солонгос) зах зээлд гаргах экспортыг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх явдал юм. Эдийн засгийн хямрал, газрын тосны үнийн огцом бууралттай холбоотойгоор макро эдийн засаг, геополитикийн сорилтууд (өрсөлдөөн нэмэгдэх, дэлхийн зах зээлийн даяаршил, эрэлтийн төвүүдийн шилжилт хөдөлгөөн) нь Оросыг байгалийн хийн зах зээлийг доройтуулахад хүргэв.

2035 он хүртэлх хугацаанд ОХУ -ын эрчим хүчний стратегийн төслийг хэлэлцэж байна (2015 оноос одоогийн байдлаар, 2020 оны 4 -р сар хүртэл). Гол шинэчлэлтүүд нь газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн дасан зохицох чадвар, шинэлэг байдалтай холбоотой юм. Байгалийн хийн үйлдвэрлэлийн стратегийн хөгжилд чиглэсэн дараагийн баримт бичиг бол “2030 он хүртэлх хугацаанд хийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ерөнхий схем” (2014 онд 2035 он хүртэл сунгасан) бөгөөд үүнд илүү нарийвчилсан төлөвлөгөө боловсруулжээ. 2015 онд нийлүүлэлтийн аюулгүй байдал, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилт тавьсан (368.8 тэрбум куб метр, 2018 онтой харьцуулахад 33% -иар өссөн) боловч экспортын хувьд шинэ ерөнхий схем нь LNG -ийн экспортыг либералчлах, Азийн зах зээл рүү чиглэсэн

экспортыг төрөлжүүлэхэд чиглэх болно. Ерөнхий схем нь зөвхөн эрчим хүчний стратеги батлагдсаны дараа хүчин төгөлдөр болох боломжтой юм. Байгалийн хий дамжуулах хоолойн тээвэрлэлтийн системийг хянадаг төрийн өмчит (50 хувиас дээш хувийг төр эзэмшдэг) компани болох Газпром дээрх хоёр баримт бичигтэй уялдуулан стратегиа хэрэгжүүлдэг. Газпромын байгалийн хийн экспортын стратеги урт хугацааны гэрээ, “экспортын нэг суваг” зарчим, дамжуулах хоолой, LNG -ийн экспортыг цаашид төрөлжүүлэхэд анхаардаг. Оросын хувьд байгалийн хийн экспортын стратегийн гол чиглэл бол тээврийн чиглэлийг төрөлжүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх, Азийн зах зээлд эрчимтэй өргөжүүлэх явдал юм. Эдгээр стратеги төлөвлөгөө нь макро эдийн засаг, геополитикийн сүүлийн үеийн өөрчлөлтийг үл харгалзан 2009 оноос хойш ихэнхдээ шинэчлэгдээгүй хэвээрээ үргэлжилж байна.


Азийн зах зээл Хятад, Энэтхэг, Япон, Өмнөд Солонгос нь Ази Номхон далайн орнуудын хамгийн том эрчим хүчний хэрэглэгчдэд төвлөрсөн их хэмжээний байгалийн хий экспортлох боломжтой. 2018 онд Хятад улс 3273 сая тонн газрын тосны эквивалент (мтоэ) хүрч, эрчим хүчний хэрэглээнийхээ хэмжээгээр дэлхийд уламжлалт тэргүүлэгч хэвээр үлдсэн бол Энэтхэг улс 809 мтоэ-ээр дэлхийд гуравдугаарт жагсчээ. Япон, Энэтхэг, Өмнөд Солонгос улсууд байгалийн хийн хэрэглээгээ урт хугацааны гэрээ байгуулан хангаж байна. Хятад бас хий, байгалийн хий (39.5%) томоохон импортлогч юм.



Эх сурвалж: Vladimir Kutcherov, Maria Morgunova, Valery Bessel, and Alexey Lopatin, “Russian natural gas exports: An analysis of challenges and opportunities. Energy Strategy Reviews 30 (2020) 100511. p.3 doi: 10.1016/j.esr.2020.100511

Азийн зах зээл Оросын байгалийн хийн экспортыг төрөлжүүлэх нь зах зээлийн үүднээс авч үзвэл чухал ач холбогдолтой (1990 -ээд оноос хойш боловсруулсан)

бөгөөд Европын экспортын чиглэлд харшлахгүй, учир нь Европ руу экспортлох хэмжээ Азийн зах зээлд гарах хэмжээ нэмэгдэхгүй хэдий ч амжилттай төрөлжүүлэх нь нарийн төлөвлөлт шаарддаг. Одоогийн байдлаар ОХУ -аас Азийн зах зээлд нийлүүлж буй экспортын хэмжээ бага байгаа боловч дэд бүтцийг хөгжүүлэх замаар хий, хий дамжуулах хоолойн аль алинаар нь нэмэгдүүлэх боломжтой. Азийн зах зээлд экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжийг олгох өөр төслүүд бол Сахалин-3 төсөл (боломжит нөөц 1.3 их наяд м3 хий), Камчаткийн хойг дахь LNG шилжүүлэн ачих терминал (2026 он гэхэд жилд 21.7 сая тонн LNG) нийлүүлэх явдал юм. Ямал хойгт байрладаг Новатек хий шингэрүүлэх үйлдвэрүүдийн нөөц, дэд бүтэц нь Оросыг Азийн зах зээлд, ялангуяа Япон, Энэтхэг, Өмнөд Солонгост их хувьцаа эзэмшихийн төлөө өрсөлдөх боломжийг олгодог. Хятадад асар их хэмжээ, төлөвлөсөн өсөлтийн боломжийн улмаас Оросын байгалийн хийн экспортын хамгийн сонирхолтой зах зээлийн боломж бий. Орос, Хятад хоёулаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар дорвитой алхам хийжээ. Газпром, Хятадын Үндэсний Газрын тос, байгалийн хийн корпораци “Сибирийн хүч” хийн хоолойгоор 2019 оноос эхлэн жил бүр 38 тэрбум м3 хийн 30 жилийн гэрээ байгуулжээ.




Хий дамжуулах хоолой болох “Сибирийн хүч-2” төсөл нь Оросын байгалийн хий экспортлох стратегийн тэргүүлэх чиглэлийг тодорхой зааж өгсөн. Оросын Украин, ЕХ -той хамтран ажилладаг боловч Азийн зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх зорилготой юм. Хэдийгээр Азийн зах зээлд өрсөлдөх чадвар өндөр, нийлүүлэлт хэтрэх аюул заналхийлж байгаа ч эдгээр зах зээл нь байгалийн хийн хэрэглээний эрчимтэй өсөлтөөс шалтгаалан бүр илүү их хэмжээний байгалийн хий нийлүүлэх боломжтой юм. Арилжааны болон стратегийн үүднээс авч үзвэл Орос улс Азийн зах зээлийг төрөлжүүлэх боломжтой тул хүртээмжийг нэмэгдүүлэхийг эрэлхийлэх нь дамжиггүй. Оросын байгалийн хий дамжуулах хоолойн зах зээлд монополист болсон Газпромын зах зээлийн либералчлал эсвэл компаниудын өрсөлдөөн нэмэгдэж улмаар Оросын хийн зах зээлийг эрс өөрчилж магадгүй юм.

Азийн зах зээлд өндөр хувьцаа эзэмшихийн зэрэгцээ Европын зах зээлд байр сууриа хадгалахын тулд Газпром үнийн бодлогыг оролцуулан зөв стратеги сонгох ёстой. Оросын байгалийн хийн экспортын өөр нэг бэрхшээл бол Азийн бүс нутагт үнийн жишиг тогтоох явдал юм. Тодруулбал, энэ нь Хятад руу байгалийн хий экспортлохтой холбоотой асуудал юм.

Төлөвлөгдсөн байгалийн хийн (LNG) төслүүд (Хүснэгт 2) нь Оросын байгалийн хий экспортлох шинэ боломжийг нээх болно. Өсөн нэмэгдэж буй импортын хэмжээ, байгалийн хийн спот зах зээлийг хөгжүүлэх зэргээр үнийн асуудалд илүү анхаарал хандуулах шаардлагатай болно. Үнийн тэнцвэргүй байдлыг бууруулах эхний алхам бол хийн төвийн сүлжээг бий болгох явдал юм. Камчаткагийн хойгт баригдаж буй ачаа тээвэрлэх терминал нь Ази номхон далайн бүс дэх Оросын анхны хийн зангилаа болох юм. “Сибирийн хүч” хийн хоолойг найдвартай ажиллуулахын тулд дахин нэг хийн зангилаа шаардлагатай болно. Экспортод чиглэсэн байгалийн хийн гол нөөцийн байршил, одоо байгаа болон ирээдүйн тээврийн систем, Азийн зах зээлд гаргах экспортын чадавхийг харгалзан хийн зангилааны хамгийн ирээдүйтэй бүс нутаг нь Зүүн Сибирийн бүс нутаг (Красноярск, Эрхүүгийн үйлдвэрлэлийн төвүүд) гэж үздэг.

Орос бол дэлхийн хамгийн том байгалийн хий үйлдвэрлэгч, экспортлогчдын нэг бөгөөд байгалийн хийн экспортын хэмжээг хадгалах, нэмэгдүүлэхэд ихээхэн бэрхшээл тулгардаг. Экспортын орлого буурах нь тус улсын эдийн засагт зайлшгүй нөлөөлөх тул байгалийн хий экспортлох стратегийн ач холбогдлыг дутуу үнэлж болохгүй. Оросын байгалийн хийн экспорт, эрчим хүчний стратеги нь 2009 оноос хойш бараг шинэчлэгдээгүй бөгөөд Оросын байгалийн хийн экспортын байршилд ихээхэн нөлөөлж буй сүүлийн үеийн өөрчлөлтийг тусгаагүй болно. Хятад, Энэтхэг, Япон, Өмнөд Солонгос зэрэг Азийн зах зээл нь Оросын байгалийн хий экспортлох хамгийн ирээдүйтэй зах зээл юм. Азийн зах зээлд өрсөлдөөн, нийлүүлэлт хэт өндөр байх эрсдэл байгаа ч Орос эдгээр зах зээлд нэвтрэх эрхийг баталгаажуулж, байгалийн хийн экспортын хувьцааг цаашид нэмэгдүүлэхийг зорих ёстой. Азийн орнууд руу чиглэсэн Оросын байгалийн хийн экспортыг өргөжүүлэх гол асуудлуудын нэг бол Зүүн Сибирийн бүсэд хийн зангилаа хөгжүүлэх явдал юм. Азийн хэд хэдэн оронтой эрчим хүчний харилцаагаа бэхжүүлснээр Орос улс эдийн засаг, эрчим хүчний төдийгүй дэлхийн шинэ дэг журмыг бий болгоход хамтран ажиллах боломжтой. Энэ нь эргээд дэлхийн тавцанд барууны нөлөөг хязгаарлах Оросын стратегийн тооцоо гэж үзэж болох ч шийдвэрлэх шинэ стратегийн сорилтыг бий болгож байна. Тухайлбал, бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд өсөн нэмэгдэж буй Хятадын нөлөөг хэт өртөхөөс хэрхэн сэргийлэх вэ? Ази руу чиглэсэн Оросын стратегийн эрчим хүчний томоохон төлөвлөгөөг хэрэгжүүлэхээс бус Ази дахь бодит болон боломжит стратегийн түншүүд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхээс давхар хамаарч байна. Байгалийн хийн хэрэглээний хамгийн том зах зээл бол АНУ, Европ, Азийн зах зээл юм. Зураг 2 үзнэ үү.

## ОХУ-ын байгалийн хийн экспортын зах зээл



XXI зуун гарснаар дэлхийн улс төр, эдийн засгийн хүрээлэл Ази номхон далай бүс нутаг, ялангуяа ЗХА-ын бүс нутагт төвлөрч байгаа нь ОХУ, БНХАУ, Япон, Солонгос зэрэг эдийн засаг, улс төрийн хувьд хүчирхэг орнууд оршиж буйтай холбоотой. Үүний зэрэгцээ тус бүс нутагт эрчим хүч тэр дундаа газрын тосны хэрэглээ их хэмжээгээр төвлөрч буй бөгөөд 2014-2040 оны хооронд тус бүс нутгийн хэрэглээ даруй 90 хувиар нэмэгдэж өдөрт 45.9 сая баррель газрын тос хэрэглэх хандлагатай<sup>21</sup> байгаа юм. Энэхүү асар их хэмжээний газрын тосны бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг ЗХА-ын бүс нутаг дахь газрын тосны цор ганц экспортлогч болох ОХУ-ын ашиг сонирхлоо хэрэгжүүлэх чухал талбар болж байна. Тиймдээ ч ОХУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалын 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйл заалтад “Дэлхийн хүчний хийгээд хөгжлийн төв нь зүүний орнууд буюу тэр дундаа Ази-номхон далайн бүс нутагт илүү ихээр төвлөрч байна”<sup>22</sup> хэмээн тусган оруулсан юм. Үүнээс гадна тус гадаад бодлогын үзэл баримтлалын 4 дүгээр бүлгийн 75 дугаар зүйлд “ОХУ нь дэлхийн эдийн засаг, улс төрийн төв болон өөрчлөгдөхийн сацуу асар хурдацтай хөгжиж буй геополитикийн бүс Ази-Номхон далайн бүс нутгийн салшгүй нэг хэсэг болсон үеэс эхлэн тус бүс нутаг нь ОХУ-ын хувьд нэн чухал бүс болж байна. ОХУ нь Сибирь болон Алс Дорнодын эдийн засгийг сайжруулах төслүүдийг хэрэгжүүлэх, Ази-Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд ил тод, эрх тэгш бүтэц, тогтолцоог бүрдүүлэх боломжийг ашиглан Ази-Номхон далайн бүс нутгийн интеграцын үйл явцад идэвхтэй оролцох сонирхолтой”<sup>23</sup> хэмээн тусгагдсан нь ОХУ-ын бодлогын чиглэл цаашид Ази-

<sup>21</sup> World Oil Outlook 2015, Organization of the, OPEC secretariat, October 2015, A-101 Vienna, Austria, 234-235-р тал, [http://www.opec.org/opec\\_web/static\\_files\\_project/media/downloads/publications/WOO%202015.pdf](http://www.opec.org/opec_web/static_files_project/media/downloads/publications/WOO%202015.pdf)

<sup>22</sup> Concept of the Foreign Policy of the Russian Federation, Approved by President of the Russian Federation V. Putin, on 12 February 2013, 303-18-02-2013, II. Foreign Policy of the Russian Federation and the Modern World-6, 2-р тал, <http://archive.mid.ru/bdomp/ns-osndoc.nsf/1e5f0de28fe77fdcc32575d900298676/869c9d2b87ad8014c32575d9002b1c38!OpenDocument>

<sup>23</sup> Мөн 16-р тал



Номхон далай цаашлаад ЗХА-ын бүс нутагт ихээхэн төвлөрч хамтын ажиллагаагаа өрөгжүүлэх хандлагатай байгаагийн илрэл юм. ОХУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалын 4 дүгээр бүлгийн 76 дугаар зүйл заалтад “...Ази дахь улс төрийн болон аюулгүй байдлын орчин нь ОХУ-ын хувьд асар чухалд тооцогдож байна...” хэмээн тусгасан. Мөн 83-р зүйл, заалтад “ЗХА нь Ази-Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцооны чухал хэсэг учир ОХУ нь тус бүс нутагт энх тайван, аюулгүй байдал, харилцан итгэлцэл, харилцан ашигтай хамтын ажиллагааны механизмыг бий болгох асуудалд идэвхтэйгээр оролцож хувь нэмрээ оруулна”<sup>24</sup> хэмээсэн байна.

ОХУ-Өрнөдийн харилцаа сөргөлдөхийн сацуу Европ дахь ОХУ-ын түнш болох Турк ОХУ-ын эсрэг үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь ОХУ газрын тос, байгалийн хийгээ Европт тасралтгүй нийлүүлэх, өрнөдийн орнуудтай улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааг өрөгжүүлэх асуудал тасалдаж магадгүй нөхцөл байдалд<sup>25</sup> хүргэсэн юм. Тиймээс ОХУ нь үндэсний эдийн засаг, эрчим хүчний аюулгүй байдлаа хангах, мөн үндэсний эрх ашиг, нөлөөллийн хүрээгээ олон улсад илүүтэйгээр бэхжүүлэхийн тулд Дорно зүгийн Ази-Номхон далайн бүс нутаг тэр дундаа ЗХА-ын бүс нутаг руу газрын тосны бодлогоо чиглүүлж энэ бүс нутагт өөрийн зах зээлийг нээхээр шамдах болсон. Үүний хүрээнд ОХУ нь Алс Дорнод, Сибирийн бүс нутгаа хөгжүүлж, түүнд тулгуурлан ЗХА-руу гарах дэд бүтцийг бий болгохоор зорьж байна. Гадаад бодлогын зорилтын хүрээнд 2030 он хүртэл газрын тос, дэд бүтэц, зам тээврийн салбартаа 325 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. ОХУ нь тус асуудлын хүрээнд дэд бүтэц, эрчим хүчний салбараа хөгжүүлэх стратегийн чухал ач холбогдол бүхий Хятад руу байгалийн хий дамжуулах хоолой барихаар болсон юм.<sup>26</sup> Мөн ОХУ нь Ази тэр дундаа ЗХА-ийн бүс нутагт эрчим хүч, газрын тосны найдвартай хэрэглэгчтэй болсноор Европын орон зайг нөхөх, тус бүс нутагт чиглэсэн газрын тосны болон бусад стратегийг идэвхжүүлж нөлөөллөө тэлэх зорилго агуулсан үйл ажиллагаануудыг дэс дараалалтайгаар авч хэрэгжүүлж<sup>27</sup> байна. Тухайлбал: ОХУ-ын ерөнхий сайд Д. Медведев “Сочи-2014” хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад ОХУ-ын Ази руу чиглэсэн стратегийг идэвхжүүлэхийн тулд дараах 3 зүйлд анхаарлаа хандуулах шаардлагатай хэмээн тэмдэглэсэн байна. Үүнд:

1. *Азийн орнуудтай харилцах харилцаандаа итгэлцлийг нэмэгдүүлэх:* Азийн орнуудтай харилцах харилцаандаа итгэлцлийг нэмэгдүүлснээр тухайн бүс нутагт улс орны нэр хүндийг өсгөх, эдийн засгийн болон улс төрийн түнштэй болох, нөлөөллийн хүрээгээ тэлэх бололцоог нэмэгдүүлэх,

<sup>24</sup> Concept of the Foreign Policy of the Russian Federation, Approved by President of the Russian Federation V. Putin, on 12 February 2013, 303-18-02-2013, IV. Regional Priorities-83, 16-p тал, <http://archive.mid.ru/bdomp/ns-osndoc.nsf/1e5f0de28fe77fdcc32575d900298676/869c9d2b87ad8014c32575d9002b1c38!OpenDocument>

<sup>25</sup> The German Marshall Fund of the United State, <http://www.gmfus.org/publications/turkey-and-russias-proxy-war-and-kurds>

<sup>26</sup> Олон улсын байдал ба Монгол улс 2015 онд, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратегийн судалгааны хүрээлэн, Улаанбаатар хот, 2016 он, “ОХУ 2015 онд: Зорилт ба Сорилт”, 7-8-р тал

<sup>27</sup> Мөн 14-р тал

дотоодын эдийн засгийг сайжруулж, шинжлэх ухаан, технологийн дэвшил гаргах, газрын тосны экспорт, импортын харилцан хамаарлаас үүдэлтэй давамгайллыг бий болгож улмаар АНУ-ын Ази, ЗХА дахь нөлөөллийг хумих юм.

2. **Тухайн бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох:** Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсоноор ОХУ нь бүс нутгийн байгууллагуудад голлох байр суурь эзлэх мөн бүс нутгийн хамтын ажиллагаанд чухал үүрэг, рольтой оролцох, цаашлаад тус бүс нутагт геополитик, геоэдийн засгийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх боломжийг нээх.
3. **Ази-Номхон далайн орнуудтай шинэ технологи, санхүүгийн төслүүдийн хамтын ажиллагааг онцгой анхаарах** явдал юм. Ази-Номхон далайн орнуудтай шинэ технологи, санхүүгийн төслүүдийн хамтын ажиллагаанд онцгой анхаарал хандуулснаар шинжлэх ухаан, технологийн инновацийн тусламжтай дотоодын эдийн засаг, газрын тосны салбарыг төрөлжүүлэх, үндэсний үйлдвэрлэлд өндөр үр өгөөжтэй, байгаль орчинд ээлтэй технологи хэрэглэх боломж бий болох юм гэж тодорхой өгүүлжээ.

## **ОХУ, БНХАУ-ын ашиг сонирхлын давхцал ба зөрчилдөөн**

XXI зуунд БНХАУ, ОХУ хоорондын харилцаа, хамтын ажиллагаа урьд өмнө нь байгаагүй түвшинд хүрсэн нь барууны нөлөөг хумих үндэсний ашиг сонирхлын нийцлээс хамаарч байгаа юм. Хоёр тал хэтэрхий ойртолгүй, тодорхой зай барьж түншлэлээ хөгжүүлснээр холбоотны биш эвслийн харилцаа тогтоож хоёр талын харилцаанд гэнэтийн саад учирч, түншлэл нь нурахаас сэргийлж байгаагаа илэрхийлдэг. Хоёр улсын ашиг сонирхлын нийцтэй байдал нь хэдийгээр ирээдүйд зөрчилдөж болох ч одоогийн түвшинд нөхцөл байдалтай нэн сайн зохицож байна хэмээн үзэж болох юм. Тухайлбал В. Путины “Алс Дорнодыг хөгжүүлэх бодлого”, Си Зинь Пиний “Хятад мөрөөдөл”<sup>28</sup> зэргээс харахад тус хоёр орон Ази дахь нөлөөллийн хүрээгээ тэлж эдийн засаг, цэрэг стратегийн хүчин чадлаа нэмэгдүүлж геополитикийн давуу тал олж авах гэсэн хүчин чармайлт явагдаж байгаа нь харагдаж байна. Гэсэн хэдий ч тэдний ашиг сонирхол өнөөгийн түвшинд нэг нэгнийгээ орлож байна. Тухайлбал, ОХУ эрчим хүч, газрын тос экспортлогч, БНХАУ эрчим хүч, газрын тос импортлогч энэхүү бие биенээ харилсан нөхсөн эрчим хүчний стратегийн нийцэл нь одоогийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гол хөдөлгөгч хүч болж өгчээ. 2013 онд Си Зинь Пин Бээжингийн удирдлагыг гартаа авснаас хойш хоёр орны харилцаа хурдацтай хөгжиж эхэлсэн. Мөн БРИКС, ШХАБ зэрэг олон улсын байгууллагуудаар дамжуулан олон талт үйл ажиллагааны хүрээнд нягт хамтран ажиллаж байна. Дэлхий дахиныг нэг өнцгөөс харж, улс орнуудынхаа стратегийн байршлын талаар төсөөтэй дүгнэлтэд хүрч

<sup>28</sup> Стратегийн судалгаа, №71, (3/2015), Зүүн Хойд Азийн уламжлалт бус аюулгүй байдлын хамтын ажиллагаа: Улаанбаатарын яриа хэлцээ ба АНДАБХАЗ, Сан Хюн И, 81-р тал

байгаа юм.<sup>29</sup>

БНХАУ-ОХУ хооронд хийн хоолой тавих бүтээн байгуулалтын гэрээг үзэглэж хоёр орны эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаа, харилцан уялдааг бэхжүүлсэн нь стратегийн зорилгоо хэрэгжүүлэх чухал үйл явдал болсон төдийгүй аль аль талдаа харилцан ашигтай бүтээн байгуулалт болж өгсөн<sup>30</sup> ч хоёр орон бүтээгдэхүүний үнийн тохиролцоонд хүрэхгүй удаан хугацаанд тохиролцож чадахгүй байсан юм. Улмаар 1000 куб.м тутамд байгалийн хийн үнийг ОХУ-ын санал болгосны дагуу 350-400 ам.доллараар тохиролцсон нь ОХУ-д таатай хэдий ч 2 дахин бага үнэ хэлсэн БНХАУ төдийлөн таашаахгүй байгаа юм<sup>31</sup>. Нөхцөл байдалд тулгуурлан харилцан буулт хийсэн хамтын ажиллагаа тус хоёр улсын дунд үүсч бий болж буй ч хоёр орны хооронд таагүй хандлага байсаар байгаа нь нэг талаараа түүхэн улбаа болон В. Путины үндсэрхэг үзэл дан ганц өрнөдийн эсрэг бус БНХАУ-ын эсрэг мөн адил чиглэдэгтэй холбоотой байж болох юм. Тиймдээ ч ОХУ Алс Дорнодын хөгжилд БНХАУ-ын оролцоог нэмэгдүүлэх худалдаанд Япон, Солонгос зэрэг өрсөлдөгчид орнуудыг татан оролцуулж байгаа нь учиртай. Нөгөө талаараа БНХАУ нь өрнөдийн түншүүдтэйгээ эрх ашгийн зөрчилдөөн үүсгэхийг хүсэхгүй байгаа тул ОХУ-тай хэрэгжүүлэх Бээжингийн төсөл, хөтөлбөрүүд удаашрах хандлагатай байгаа<sup>32</sup> юм. Мөн түүнчлэн хоёр улс түүхийн туршид холбоотны харилцаа аюултай болохыг хангалттай мэдэрсэн. Тэдний өмнө нь тогтоож байсан холбоотны харилцаа нь дахин холбоотны харилцаа тогтооход сөргөөр нөлөөлж байгаа юм.<sup>33</sup> Магадгүй энэ нь цаашлаад эрчим хүчний салбарт том хэмжээний сөргөлдөөн бий болгож магадгүй.

Өрнөдийн орнуудтай эдийн засаг, гадаад худалдааны тэнцвэрийг хадгалж Зүүн бүс нутгаа хөгжүүлэхийг зорьж байсан ОХУ-ын өмнөх үеийн бодлого, зорилтууд өөрчлөгдөж байна. Алс, Дорнод, Зүүн Сибирь, Арктикийн бүс нутгийн хөгжлийг хурдацтайгаар нэмэгдүүлж Ази руу гарах гарц болгох талаар бүлэг болгонд шууд болон тойруу замаар оруулж<sup>34</sup> өгсөнтэй холбогдон БНХАУ-тай эдийн засгийн харилцаагаа бэхжүүлж, Япон, Солонгос хийгээд Ази номхон далайн орнуудтай эрчим хүч, эдийн засгийн харилцаагаа нэмэгдүүлэх ОХУ-ын нөлөө ихээр өсөн нэмэгдэж байна. Үндсэндээ ОХУ нь улсын цаашдын хөгжлийн чиг хандлага ЗХА-ын бүс нутагтай нягт холбоотой нь улам тодорхой болж байгаа бөгөөд тус улсын эрчим хүчний дипломат ажиллагаа, нөлөөллийн бүсээ тэлэх үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Нөгөөтэйгүүр, ЗХА-ийн бүс нутгийн томоохон тоглогчид болох БНХАУ, Япон, Өмнөд Солонгос, Тайвань зэрэг өрнөдийн улсуудтай харилцаагаа

<sup>29</sup> Геополитик судалгааны хүрээлэн, Геополитик судлал, №1, 2015 он, Хятад, Оросын холбоотны биш боловч хөл нийлүүлсэн алхаа, 128-129-р тал

<sup>30</sup> [http://www.chinadaily.com.cn/china/2015-12/08/content\\_22664434.htm](http://www.chinadaily.com.cn/china/2015-12/08/content_22664434.htm)

<sup>31</sup> <http://www.gazprom.com/about/production/projects/pipelines/ykv/>

<sup>32</sup> Олон улсын байдал ба Монгол улс 2015 онд, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратегийн судалгааны хүрээлэн, Улаанбаатар хот, 2016 он, “ОХУ 2015 онд: Зорилт ба Сорилт”, 16-р тал

<sup>33</sup> Геополитик судалгааны хүрээлэн, Геополитик судлал, №1, 2015 он, Хятад, Оросын холбоотны биш боловч хөл нийлүүлсэн алхаа, 130-р тал

<sup>34</sup> Энергетическая стратегия России на период до 2035 года, проект утверждена распоряжением Правительства Российской Федерации, 56-р тал [http://www.energystrategy.ru/ab\\_ins/source/ES-2035\\_09\\_2015.pdf](http://www.energystrategy.ru/ab_ins/source/ES-2035_09_2015.pdf)

хэвийн хадгалах сонирхол хүчтэй хэвээр байна. Учир нь өрнөдийн орнуудтай улс төр, цэрэг стратеги, геополитикийн хувьд ихээхэн зөрчилдөөд буй ОХУ-тай стратегийн чухал салбарууд болох газрын тосны салбарт хамтын ажиллагааг өргөжүүлж харилцан хамаарлаа ихэсгэж буйд өрнөдийн орнууд АНУ-д төдийлөн таашаахгүй юм. Энэ нь цаашдаа ЗХА-ын эрчим хүч томоохон импортлогчид болох БНХАУ, Япон, Өмнөд Солонгос болон АНУ улс хоорондын харилцаанд сэв суулгах магадлалтай. Эдгээр орнуудын болгоомжилсон нөхцөл байдал нь ОХУ-ын тус бүс нутаг дахь түлш, эрчим хүч, газрын тосны дипломат ажиллагаа болон бусад стратегийн зорилтуудаа хэрэгжүүлэхэд саад учруулж нөхцөл байдлыг удаашруулж байгаа юм.<sup>35</sup>

2016 оны 4 сард ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавров Монгол улсад албан ёсны айлчлал хийхдээ Монгол Улсын Гадаад хэргийн яаманд “ОХУ-ын Зүүн Хойд Ази дахь гадаад бодлого” сэдвээр лекц уншсан билээ. Тэрээр ОХУ-ын ЗХА-д чиглэсэн бодлогыг тодорхойлж өгсөн юм. “...Орос улс бол Ази-Номхон далайн бүс нутгийн салшгүй нэгэн хэсэг байсан, байсаар ч байгаа, хойшид ч байх болно. Ази-Номхон далайн чиглэл бол манай гадаад улстөрийн бодлогын гол чиглэлүүдийн нэг болж байдаг нь зүй ёсны хэрэг билээ. Бидний хувьд тус бүс нутагтай хамтран ажиллах явдал нь стратегийн шинж чанартай бөгөөд наад зах нь XXI дүгээр зууны турш үргэлжилнэ гэдгийг ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин удаа дараа мэдэгдэж байсан. Ази-Номхон далайн бүс нутагт үр дүнтэй хамтран ажиллаж, хөгжих зайлшгүй нөхцөл бол бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх явдал билээ. Харамсалтай нь сүүлийн үед тус бүс нутаг дахь цэрэг-улстөрийн нөхцөл байдал улам эдрээ түвэгтэй болсоор байна. Газар нутгийн маргаанд ашиг сонирхлууд зөрчилдөж, олон улсын терроризмын аюул занал улам бүр нэмэгдсээр. Эдгээрээс гадна, хар тамхины наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус цагаачлал, далайн дээрэм, хүнсний болон эрчим хүчний хангамжид үүсэх хүндрэл зэрэг асуудлууд гарч ирлээ. Энэ бүхнээс улбаалан, эвслийн бус хандлагын үндсэн дээр, олон улсын эрхзүйг хүндэтгэх, маргаан сөргөлдөөнийг энхийн аргаар зохицуулах, хүч үл хэрэглэх, хэрэглэхээр заналхийлэхгүй байх, улс орнуудын засгийн газруудыг түлхэн унагаах эсвэл бусад орны тогтвортой байдлыг бусниулахад чиглэсэн аливаа үйл ажиллагааг дэмжихээс татгалзах гэсэн зарчмуудын үндсэн дээр Ази-Номхон далайн бүс нутагт эрх тэгш бөгөөд хуваагдашгүй аюулгүй байдлыг хангах найдвартай механизмыг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага урган гарч ирж байгаа<sup>36</sup>” хэмээсэн юм. Энэ нь ОХУ-ын бодлого стратеги цаашдаа ЗХА-д илүүтэй төвлөрнө гэсэн санааг агуулж байгаа бөгөөд мөн тус нутаг дахь эрчим хүчний аюулгүй байдлыг хангана гэсэн санааг агуулж байгаа юм.

Олон улсын харилцаанд цаг уурын өөрчлөлт гэсэн хуучин цагийн шинэ асуудал хүч түрэн орж ирж дэлхий нийтээрээ хамтдаа шийдэх гарц хайж байгаа өнөө үед улс

<sup>35</sup> Олон улсын байдал ба Монгол улс 2015 онд, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратегийн судалгааны хүрээлэн, Улаанбаатар хот, 2016 он, “ОХУ 2015 онд: Зорилт ба Сорилт”, 28-р тал

<sup>36</sup> С.В.Лавров: Евразийн их түншлэлээр Монгол Улсад олон боломж гарч ирнэ., <https://www.montsame.mn/mn/read/90070>

орон бүр нүүрсустөрөгчийн нэгдлүүд болох газрын тос, нүүрс зэрэг хамгийн өргөн хэрэглэгддэг хэрнээ хамгийн их бохирдол ялгаруулдаг бүтээгдэхүүн, түүхий эдийн хэрэглээгээ хумих асуудал хурцдаж байна. ОХУ-ын хувьд энэ нь гадаад бодлогын стратегид нөлөөлөх хэмжээний асуудал болжээ. Улс орнууд байгаль орчинд ээлтэй байдлаар байгалийн хийг ашиглах сонирхол нэмэгдэж буйтай холбоотой ОХУ нь газрын тос, байгалийн хийн нөөцөө хослуулан экспортлох стратеги барьж байна. Хэдийгээр дэлхий даяар газрын тосны хэрэглээ улам бүр өсөн нэмэгдэж үүнийгээ дагаад ОХУ-ын газрын тосны бодлого улам бүр нарийсч байгаа боловч Ази дахь байгалийн хийн хэрэглээ цаашид улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь ОХУ-ын байгалийн хийн бодлогоо улам бүр эрчимжүүлэх нэгэн шалтгаан болж газрын тос, байгалийн хийн хосолсон хүчтэй гадаад бодлогыг бүс нутагтаа явуулах боломжийг улам бүр нээлттэй болгосоор байна. Тухайлбал, 2015 оны Парис хотноо зохион байгуулагдсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн талуудын 21 дүгээр Бага хурлаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудалд бүх улс орон дагаж биелүүлэх Парисын хэлэлцээр баримт бичгийг баталсан<sup>37</sup> нь нүүрс, газрын тосны хэрэглээг бууруулж байгалийн хий буюу хүхрийн ялгаруулалт багатай бүтээгдэхүүнүүдийг сонгоход улс орон бүр анхаарч ажиллах болсон тул ОХУ-ын байгалийн хийн бодлого түлхүү эрчимжүүлэх нөхцлийг ч бүрдүүлж байна.

### ***Орос, Энэтхэгийн эрчим хүчний хамтын ажиллагаа:***

Энэтхэг улс нүүрсустөрөгчийн хэрэглээгээр дэлхийд гуравт, Ази Номхон далайн орнуудаас хоёрт ордог. Газрын тос, байгалийн хийн хэрэглээний өсөлтийн хурдаар Энэтхэгийн зах зээлийг дэлхийн хамгийн ирээдүйтэй гэж үздэг. Олон улсын эрчим хүчний агентлаг (ОУЭА) ойрын 20 жилд дэлхийн эрчим хүчний эрэлтийн өсөлтийн дөрөвний нэгийг Хятад биш Энэтхэг улс хангаж, 2030 он гэхэд эрчим хүчний хэрэглээгээр Европын Холбоог гүйцэнэ гэж үзэж байна. Энэ улсын газрын тосны эрэлт 2019 онд өдөрт 5 сая баррель байсан бол 2040 он гэхэд өдөрт 8,7 сая баррель болж өснө. Газрын тос боловсруулах хүчин чадал өдөрт 7.7 сая баррельд хүрнэ гэж үзжээ. Энэтхэгт нийлүүлсэн газрын тосны хэмжээгээр АНУ тус улсын нийт импортын 14 хувийг эзэлдэг Ирак Энэтхэгийн гол экспортлогч хэвээр байв. Персийн булангийн орнууд Энэтхэгийн импортын 60 гаруй хувийг эзэлж гол түнш хэвээр байна.

Сүүлийн жилүүдэд Дорнийн эдийн засгийн чуулга уулзалтад Энэтхэг улс идэвхтэй оролцож Шинэ Дели ОХУ-тай эрчим хүчний салбарт хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх сонирхолтой байна. Энэтхэг улс газрын тосны 80 гаруй хувь, байгалийн хийн 45 гаруй хувийг гаднаас импортлох шаардлагатай болдог бөгөөд өдөрт 600 орчим мянган тонн газрын тос хэрэглэдэг улсын хувьд эрчим хүчний түүхий эдийн эх үүсвэрээ төрөлжүүлэх нэн шаардлагатай. Форумын

<sup>37</sup> The Paris Climate Agreement: <http://eciu.net/briefings/international-perspectives/the-paris-climate-agreement>

үеэр Энэтхэгийн Газрын тос, байгалийн хийн сайд Хардип Сингх Пури Оросын “Роснефть”, “Новатек”, “Газпром нефть”, “Сибур” компаниудын удирдлагуудтай уулзалт хийжээ.

Орос, Энэтхэгийн хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны тэргүүлэгч нь “Роснефть” компани юм. “Роснефть болон Энэтхэгийн түншүүдийн оролцоотой төслүүдэд оруулсан харилцан хөрөнгө оруулалтын хэмжээ 17 гаруй тэрбум доллар нь Орос, Энэтхэгийн нийт хөрөнгө оруулалтын талаас илүү хувь юм. “Роснефть” компани Ванкор газрын тос, хийн конденсат ордыг ашиглаж байгаа Ванкорнефть компанийн хувьцаа эзэмшигч болсон төдийгүй Энэтхэгийн ONGC 26%-ийг худалдаж авсан бол Oil India, Indian Oil Corporation, Bharat Petroresources-ийн консорциум 23.9%-ийг эзэмшиж байна. Энэтхэг улс мөн Восток Ойл төсөлд оролцох төлөвтэй байна.

Роснефть нь эргээд Вадиар хотод өндөр технологийн газрын тос боловсруулах үйлдвэр, Энэтхэгт хамгийн хурдацтай хөгжиж буй шатахуун түгээх станцуудын нэг болох Энэтхэгийн Nayara Energy компанийн хувьцаа эзэмшигч юм. Одоогийн байдлаар Nayara Energy компани боловсруулах үйлдвэрийн эхний шатанд жилд 450 мянган тонн хүртэл полипропилен үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрүүдийг барьж, үйлдвэрүүдийн сүлжээг өргөжүүлэхээр төлөвлөж байна. Энэтхэгт шатахуун түгээх станцуудыг ойрын 3 жилд 8 мянга хүртэл тоогоор нэмэгдүүлэх төлөвтэй байна. Үүний зэрэгцээ Владивостокт болсон яриа хэлэлцээ Оросын байгалийн хийн төслүүдийг Энэтхэг сонирхож байгааг харуулсан. Ялангуяа ONGC болон Petronet (LNG) консорциум Арктикийн LNG-2-ын 9.9 хувийн хувьцааг худалдан авах талаар хэлэлцэж байгаа гэсэн мэдээлэл гарсан байна.

Энэтхэгээс ОХУ-д суугаа Элчин сайд Венкатеш Варма РИА Новости агентлагт өгсөн ярилцлагадаа: “...Оросын LNG-ийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Одоогийн байдлаар эрчим хүчний салбарт харилцан их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байгаа хэдий ч Оросоос Энэтхэгт шингэрүүлсэн нүүрсустөрөгчийн импорт дөнгөж 1 хувь байгааг нэмэгдүүлэх бодолтой байна” гэж хэлэв.

Ойрын жилүүдэд Энэтхэгийн эдийн засаг жил бүр 8-10 хувиар өсөж, эрчим хүчний хэрэглээ хоёр дахин өсөх төлөвтэй байгаа юм. Энэтхэгт шингэрүүлсэн байгалийн хийн борлуулалт 2040 он гэхэд дөрөв дахин нэмэгдэж, 124 тэрбум шоо метр болж тус улс нийт хийн хэрэгцээнийхээ 61 орчим хувийг шингэрүүлсэн хийгээр хангана. Энэтхэг одоогийн байдлаар LNG импортын хэмжээгээр 4-р байрт, 26 тэрбум шоо метр том хэрэглэгч зах зээл тул Оросын газрын тос, байгалийн хийн компаниудын хувьд Энэтхэг хамгийн сонирхолтой чиглэл болсон. 2021 оноос хамтын ажиллагаагаа эрчимжүүлж Орос, Энэтхэгийн хооронд газрын тос, байгалийн хийн салбарт идэвхтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал, 3-р сард Орос, Энэтхэг улсууд хийн асуудлаар ажлын хэсэг байгуулахаар тохиролцсон бол 3-р сарын эхээр Москвад Энэтхэгийн эрчим хүчний төв нээгдэв. Энэтхэгийн засгийн газар эрчим хүчний аюулгүй байдлыг хангахын тулд нүүрсустөрөгчийн

нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх хүсэлтэй байгаа нь Орос улс чухал түнш болох шалтгаан юм. Энэтхэгийн хөрөнгө оруулагчид газрын тосны төслүүд (ялангуяа Восток Ойл) болон байгалийн хийн Arctic (LNG-2) төслийг сонирхож байгаа боловч тохиролцоонд хүрсэн талаар хараахан зарлаагүй байна.

Эрчим хүч, санхүүгийн хүрээлэнгийн Эрчим хүчний ерөнхий захирал Алексей Громов "... Энэтхэг бол ойрын болон дунд хугацаанд нүүрсустөрөгчийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тал дээр Оросын хамгийн ирээдүйтэй түншүүдийн нэг, Хятадаас ч илүү юм. Энэтхэгийн хувьд эрчим хүчний худалдааг нэмэгдүүлэх асар том хэтийн төлөв харагдаж байгаа Энэтхэгнау эрчим хүчний төслүүдэд Оросын компаниудын оролцоо, түүнчлэн Оросын уул уурхайн бүтээн байгуулалтад Энэтхэгийн хөрөнгийн оролцоо нэмэгдэх болно" гэжээ. Оросын компаниудаас Газпром энэ чиглэлээр асар их туршлагатай тул хийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, Энэтхэгийн муж улсуудыг Оросын нэгэн адил хийн хангамжийн нэгдсэн системд холбогдох төслүүдийг сонирхож байгаагаа илэрхийлжээ.

Энэтхэгт эрчим хүчний дотоод зах зээлийг төрөөс бүрэн зохицуулдаг. Тухайлбал, дотооддоо үйлдвэрлэсэн газрын тос, хий импортынхоос хамаагүй хямд зарагддаг нь салбарын хөгжлийг удаашруулж, төрийн өмчит компаниудын оролцоо давамгайлж (Хятадын эдийн засгаас хамаагүй их оролцоотой) байдаг нь зохицуулалт өндөр, бизнесийн ашиг багатай байхад хүргэдэг. Улмаар Энэтхэгийн дотоодын зах зээлд чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалттай газрын тос, байгалийн хийн аливаа төслүүдийн ашгийг бууруулдаг. Тухайлбал, Арабын тэнгис дэх газрын тосны талбайг хөгжүүлэх нэг нөхцөл нь эдгээр ордуудаас газрын тосыг дотоодын зах зээлд нийлүүлэх заалт юм. Ийм төслүүдийг хэрэгжүүлэхэд бүх компаниуд бага ашиг орлоготой тул гадаадын хөрөнгө оруулалтыг татахад саад учруулдаг Энэтхэгийн эрчим хүчний бодлогын нэг онцлог ажээ.

Оросын газрын тос Энэтхэгийн зах зээл дээр Ойрхи Дорнодтой хэрхэн өрсөлдөж чадах вэ гэсэн асуултад Громов хариулахдаа, ложистикийг тооцсон ч амжилттай өрсөлдөж чадна. "Орос Энэтхэгийн газрын тос боловсруулах зах зээлд хэдийнэ нэвтэрсэн. Роснефть бол Энэтхэгийн хамгийн том газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьцаа эзэмшигч. Энэ төслийг Оросын нэгэн компанийн тосыг түүхий эд болгон ашиглах нөхцөлөөр хэрэгжүүлж байгаа. Орос улс Энэтхэгийн зах зээлд Ойрхи Дорнодын газрын тос нийлүүлэгчидтэй өрсөлдөх сайн боломж байна. Зөвхөн Катарын шингэрүүлсэн хий Оросын түүхий эдээс хямд, ложистикийн богино хөшүүрэгтэй холбоотой тул харьцангуй өрсөлдөх боломжтой. Хамгийн гол нь Энэтхэг улс эрчим хүчний засаглалаа шинэчлэхээс татгалзаж байгаа нь гол саад болж байна. Шатахууны үнэ өөр өөр байдаг - дотооддоо үйлдвэрлэсэн "цэнхэр түлш" импортынхоос хямд байдаг асуудал шийдэгдвэл Оросын байгалийн хийн (LNG) экспортын боломжит зах зээл юм. Орос, Энэтхэг хоёр улс эрчим хүчний хамтарсан төслүүдийг харилцан сонирхож байгаа хэдий ч урт хугацааны хэлэлцээ шаардагдсан Орос, Хятадын эрчим хүчний гол гэрээнүүд хэрхэн байгуулагдсаныг эргэн санах нь зүйтэй хэмээн өөдрөгөөр төсөөлж байна.

Монгол улсын хувьд Энэтхэг улс газрын тосны салбарын гол хөрөнгө оруулагч түнш юм. БНЭУ-ын 1,236 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр Дорноговь аймгийн Алтанширээ сумд баригдаж буй “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ий бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. Манай улсын газрын тосны хайгуул олборлолтын үйл ажиллагаа 2005 оноос эхлэн эрчимжсэнээр батлагдсан нөөцтэй болж, олборлосон тосоо БНХАУ-д экспортолж байна. 2010 онд батлагдсан газрын тосны нөөц ашиглах төлөвлөгөөтэй уялдуулан 1,5 сая тонн түүхий тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг 2023 онд ашиглалтанд оруулахаар зорьж байна.

### **Хятад-Монгол-ОХУ эдийн засгийн корридор ба эрчим хүч**

2015 онд ОХУ-ын Уфа хотод Монгол, БНХАУ, ОХУ-ын гурван талт эдийн засгийн корридор байгуулах тухай санамж бичигт гурван улсын төрийн тэргүүн нар гарын үсэг зурсан юм. Энэ нь Монгол улсын санаачилсан “Талын (Хөгжлийн) зам”, ОХУ-ын “Транс-Евроазийн бүс”, БНХАУ-ын “Торгоны зам” төслүүдийг уялдуулан, нэгтгэсэн зүйл боллоо хэмээн гурван улсын төрийн тэргүүн нар илэрхийлсэн хурлын дараа ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин мэдэгдэхдээ: “Бид БНХАУ-ын Дарга Си Зинь Пиний санаачилсан эдийн засгийн корридор байгуулах санамж бичигт гарын үсэг зурж баталсан” хэмээжээ. Өвөр Монголын Хөгжлийн Судалгааны Төвөөс гаргасан мэдээнд Хятад, Орос, Монголын эдийн засгийн хонгил нь “Нэг бүс нэг зам-ын төлөвлөгөөний бүтээн байгуулалтын 6 томоохон эдийн засгийн хонгилын төлөвлөгөөний хамгийн эхэнд жагсаагдсан ба гурван улсын дагуу эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимтэй ахиулж, бүх Евразийн эх газрын хөгжлийг дайчлах болно хэмээжээ.

БНХАУ “Торгоны замын эдийн засгийн бүслүүр” санаачилгын зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ.<sup>38</sup> Үүнд:

1. Хятадыг эрчим хүчний эх үүсвэрээр урт хугацаанд, найдвартай хангах
2. Эдийн засгийн өсөлтийг хангах Хятадын гадаад зах зээлийг өргөтгөх
3. Хоцрогдолтой бүс нутгаа хөгжингүй болгох
4. Мөнгөн хуримтлалыг бодит баялаг болгох хэмээх зорилт нь “нэг зам, нэг бүс” хөтөлбөрийн арга хэмжээнүүдийн ихэнх нь Хятадын хөрөнгө оруулалт, стандартаар баригдахтай холбоотой юм.
5. “Зөөлөн хүч”-ний бодлогоор дамжуулан эдийн засгийн хэлхээ холбоог сайжруулах зорилготой.

Хятадын Үндэсний хөгжил, өөрчлөлтийн хороо, ГХЯ, Худалдааны яамнаас баталж гаргасан “Нэг бүс, Нэг зам” санаачилгын хүрээнд эдийн засгийн корридоруудад гадаад орнуудтай хамтын ажиллагааг дэд бүтцийн салбарт хөгжүүлэх үндсэн чиглэлүүд болох авто зам, төмөр зам, боомтууд, онгоц буудлууд, газрын

<sup>38</sup> “Гурван улсын эдийн засгийн корридорыг Монгол улсын геоздийн засгийн сонирхолтой уялдуулах нь” Бодлогын судалгааны төв. Удам соёл. 2017 он. тал 9



тос, хий дамжуулах хоолой, газрын тос боловсруулах үйлдвэр, холбоо харилцаа, эдийн засгийн тусгай бүс байгуулах зэргээр тодорхойлсон<sup>39</sup> байдаг.

Монгол улс БНХАУ-ын Дарга Си Жин Пиний 2013 оны 9 дүгээр сард санаачилсан “Нэг бүс, нэг зам” санаачилгад хамрагдан, хамтарч ажиллах болсон. Гурван улсын эдийн засгийн коридор бол ЕАЭЗХ, Торгоны замын нэг зам, бүслүүр, Монголын “Хөгжлийн зам” хөтөлбөрийн интеграцийг хэрэгжүүлж, хоршин хөгжих явдалд үндэслэгдсэн байна. 2017 онд Москвад зохиогдсон гурван улсын шинжээчдийн түвшний II уулзалтаар Монгол Улсын ГХЯ, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил шинэчлэлийн хороо хооронд Монгол, Орос, Хятадын “Эдийн засгийн коридор”-ын хэрэгжилтийг урагшлуулах хамтарсан механизм байгуулах тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн агуулгыг тохиролцож, гарын үсэг зурж, талууд “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т тусгагдсан 32 төслөөс тэргүүлэх ач холбогдол өгч эхний ээлжид хэрэгжүүлэх төслүүдийн талаар хэлэлцэж, *нэгд*, төмөр замын төв коридор, *хоёрт*, авто замын төв коридор байгуулах, *гуравт*, Монгол, Оросын цахилгаан эрчим хүчний сүлжээг шинэчлэхэд Хятадын аж ахуйн нэгжүүд оролцох боломжийг судлах зэрэг 3 төслийг энэхүү санамж бичгийн хавсралтад оруулсан байна.

Талуудын тохиролцсон анхны төсөл хэрэгжиж эхлэхэд “Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төв”-ийг Улаанбаатар хотноо байгуулж ажиллахаар гурван тал санал нэгджээ.<sup>40</sup> Түүхэн ховор боломж тохиож байгааг гүнзгий ухамсарлаж Монголын нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх томоохон төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг зөв сонгох нь чухал юм. Эдгээр төслийг олон улсын банк, санхүүгийн хөрөнгөөр, эсвэл тэдгээрийн оролцоотой санхүүжүүлэхийг тэргүүн ээлжид анхаарах ёстой. Хэрвээ хөрш орнуудын компаниудаас санхүүжүүлэх бол төрийн бус өмчлөлтэй бүтцүүдийг сонгох нь зүйтэй юм. Мөн 3 улсын эдийн засгийн ашиг сонирхолыг уялдуулах нь хамгийн чухлаар тавигдаж байна. Хүч тэнцвэргүй 3 улсын ашиг сонирхлыг тодруулбан авч үзвэл ихээхэн зөрүүтэй байдал харагдана.

**Хятадын сонирхол:** Хятадын эдийн засгийн гол төвлөрөл Бээжин, Хэбэй, Хэнань хавьд ногддог. Манай төмөр зам дээр дээрх мужуудтай хамгийн ойр учраас Хятадын аж үйлдэржсэн мужуудыг Оросын байгалийн баялаг төвлөрсөн бүсүүдтэй хямд зардлаар холбох боломжтой. Хил залгаа орших Монголын ордуудаас зэс, төмөр, молибден, гянт болд, цайр зэрэг суурь төмөрлөг, нүүрс, нефть, цахилгаан зэрэг эрчим хүчийг импортлох нь өртгийн хувьд хямд юм. Хятадын дотоодын эдийн засгийн хэрэгцээ, коридортой нягт холбоотой. Учир нь Хятад үйлдвэрлэлийн илүүдэлтэй нь тус улсын үйлдвэрлэлийн хэрэглээ 75% байна. Тиймээс илүүдэл барааг гадаад зах зээл рүү хямдаар гаргах эсвэл өөр улс руу үйлдвэрлэлээ гаргаж, хөгжүүлэх зорилготой.

**Оросын сонирхол:** Хятадаас Европ руу чиглэсэн ачааг Монголын нутгаар

<sup>39</sup> Vision and actions on jointly building Belt and Road, 29 March, 2015, Xinhua, April 10, 2017

<sup>40</sup> Д.Уламбаяр., Геополитикийн орчны өөрчлөлт ба МУ-ын гуравдагч хөршийн бодлогын парадигм, Олон улсын харилцаа сэтгүүл, 2017№1/36, т.92

тээвэрлэх нөхцөлд Транссибирийн төмөр замын ачаалал нэмэгдэж Оросын талд орох орлогыг нэмэгдүүлэх, ялангуяа “Улаанбаатар” төмөр зам нь Монгол-Оросын хамтарсан аж ахуйн нэгж тул түүний ачааллыг нэмэгдүүлэх нь мөн орлого нэмэгдүүлэхэй холбоотой. Дэд бүтцийн хөгжлөөр дамжуулан <sup>41</sup> Сибирь, Алс Дорнодын хөгжилд түлхэц үзүүлэхэд анхаарч байна.

**Монголын сонирхол:** Дэд бүтцийн хөгжил, мөн дамжин өнгөрөх тээврийн таатай орчин бүрдүүлэхэд ихээхэн анхаарч байна. Монгол-Хятад, Монгол-Оросын хоёр талын хүрээнд хэрэгжиж буй тодорхой төслүүд, гэрээ хэлэлцээрийг коридорын ерөнхий хүрээнд хамааруулж уялдаа холбоог хангах хэрэгтэй. Хэдийгээр дээрх төсөл нь Монгол улсын дамжин өнгөрөх тээвэр, Европ зэрэг “гуравдагч хөрш”-ийн орнуудад бараа бүтээгдэхүүн нийлүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлж болох боловч нөгөөтэйгүүр маш том сорилт болж байна. Учир нь Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь хөрш орнуудын Монгол улс дахь нөлөөг дипломат арга, хамтын ажиллагаагаар тэнцвэржүүлэх зорилттой боловч энэ төсөл, коридор нь хөрш орнуудын нөлөөг нэмэгдүүлэх нь тодорхой юм.

1990-ээд оноос хойш байгалийн хийн хоолойг Монгол улсын газар нутгаар дамжин өнгөрүүлэх талаар яригдаж байсан хэдий ч бодит байдал дээр ОХУ нь байгалийн хийн үнээ өсгөх нэгдүгээр зорилт, байгалийн хийн асуудал дээр бие даасан байдлаа хадгалах хоёрдугаар зорилт, үндэсний эрх ашгаа хамгаалах гуравдугаар зорилтын хүрээнд Алс Дорнодоор дамжуулан Владивостокоор тус хийн хоолойгоо тавихаар болж байсан түүхтэй. Мөн Хятадын эрчим хүчний түүхий эдийн хангамж гаднаас хамаарах нь нэмэгдсээр байгаа талаар, тухайлбал газрын тосны импортын хамаарал 58%, байгалийн хийнх 31% хүрээд байгаа гэсэн тооцоо байна. Урд хөрш маань Япон, Өмнөд Солонгос хоёр шиг газрын тос, болон эрчим хүчний түүхий эдээр гаднаас бүрэн хамааралтай улс биш ч авч буй хэмжээгээрээ асар их жин дардаг учраас эх үүсвэрээ аль болох олон салаалж, нэг эх үүсвэрээс хамааралтай байхгүйг хичээж дэлхий даяар хамтын ажиллагаа өрнүүлж, 4 том стратегийн бүсийг бий болгоод байгаа нь Саудын Араб төвтэй Ойрх Дорнод, Казахстан төвтэй Төв Ази, Венесуэл төвтэй Өмнөд Америк, Судан төвтэй Хойд Африк юм. Гэвч стратегийн нөөц болсон газрын тосныхоо 80%-ийг Маллакийн хоолойгоор дамжуулан далайгаар тээвэрлэж авдаг нь их эрсдэлтэй. Тээврийн энэ хамаарлыг саармагжуулахын тулд хятадууд хуурай газраар зүүн хойд, баруун хойд, баруун өмнөд гэсэн гурван чиглэлээр газрын тос, байгалийн хийн хоолой татаж байна. Хятад, Орос хоёрын хамгийн гол тохироо бол газрын тос бөгөөд нөөц нь хумигдаж байгаа ч Орос улс ирэх 10 жилд 70 сая тонн газрын тос буюу 85 тэрбум ам.долларын тосыг Хятадад нийлүүлнэ гэдгээ гэрээгээр баталгаажуулсан юм.

Монголоор дайруулах энэ маршрут нь хийг шууд Зүүн Хойд Хятадад, тухайлбал, Бээжингийн районд шууд хүргэхээс гадна тал хээрийн нутгаар дайран өнгөрөх тул хоолойг хямд өртгөөр, богино хугацаанд барих боломжтой. Үүний зэрэгцээ хоолойг

<sup>41</sup> Бодлогын судалгааны төв. “Гурван улсын эдийн засгийн коридорыг Монгол улсын гео-эдийн засгийн сонирхолтой уялдуулах нь”: Судалгааны бүтээл. Удам соёл. 2017 он. тал 30

барихдаа ТрансМонголын төмөр зам, Алтанбулаг-Эрээний автозамын дагуух бэлэн дэд бүтцийг ашиглах давуу талтай. Элчин сайд асан Л.Хангай<sup>42</sup> “...Украин улс 2018 онд Европ руу 86 тэрбум шоо метр хий дамжуулсны төлбөрт жилд 3 тэрбум долларын орлого, Беларусь улс 1,6 тэрбумыг тус бүр олжээ. Хэрэв манай улс жилдээ 38 тэрбум шоо метр хий дамжуулна гэвэл 1 тэрбум орчим долларын орлого, 50 тэрбум шоо метрийг дамжуулна гэж тооцвол дээрх тоо өсөх нь лавтай. Хийн хоолойг барих ажлын оргил үед 3700 хүн, барьж дууссаны дараа 1300 гаруй хүн ажлын байртай болно гэсэн тооцоог Оросын “Русиа Петролиум” компани бүр 2000 онд хийсэн талаар элчин сайд асан Л.Хангай дурьдсан байдаг. Мөн хийн салбар дахь нэг ажлын байр нь бусад салбарт 4-6 ажлын байрыг бий болгох төдийгүй хийн хоолой тавьснаар Сүхбаатар, Дархан, Улаанбаатар, Сайншанд хотуудын агаарын бохирдлыг 90-ээс дээш хувиар бууруулах боломжтойг онцолжээ.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2021 оны 4 сард Төрийн Думд илгээсэн захидалдаа хувийн байшингуудыг 2030 онд хийгээр бүрэн хангах хөтөлбөрийн хүрээнд айл өрхүүдээс төлбөр авахгүйгээр хийн шугамд холбох<sup>43</sup> боломжийг дурьдсан байна. Оросын Европын бүс нутагт нэг байшинг 50-120 мянган рублиэр (5 сая орчим төгрөг) шугамд холбоно гэж тооцоолсныг үзвэл, Улаанбаатарын гэр хорооллын 200 мянга гаруй байшинг хийн шугамд холбоход 1 их наяд төгрөгийн зардал гарна гэсэн баримжаа тоо байна. Хийн хангамжийн дэд бүтцийг байгуулахад тодорхой хэмжээний зардал гарна гэж үзвэл транзит тээврийн жилийн төлбөр болох 1 тэрбум доллароор гэр хорооллыг бүрэн газжуулж болох ажээ.

### ***ОХУ-ын Азийн эрчим хүчний стратеги Монгол Улсад нөлөөлсөн нь:***

Азийн эрчим хүчний томоохон зах зээлд байгалийн хий нийлүүлэхээр оросууд хоёр мега төсөлд төвлөрч байгаа юм. Эхнийх нь Сибирийн нутгаар 2159 км үргэлжлэх хоолойгоор Хятадын зүүн нутагт байгалийн хий нийлүүлж эхэлсэн бол удаах нь Монголын талтай яриа хэлэлцээрийн түвшинд ахиж буй “Сибирийн хүч 2” хоолой байгуулах төсөл билээ.

<sup>42</sup> Л.Хангай: Монголоор да мжуулан хийн хоолой барих ажил өнөө маргаашгүй эхэлчихнэ гэж бодож болохгүй: <https://www.montsame.mn/mn/read/220899>

Послание Президента Российской Федерации от 21.04.2021 г. 6/н <http://www.kremlin.ru/acts/bank/46794/page/3>

<sup>43</sup>

Зураг 3

## Сибирийн хүч I, II байгалийн хийн маршрут



“Газпром” ОХУ-БНХАУ-ыг холбох байгалийн хийн хоолойн хоёр төсөл хэрэгжүүлж буй. Энэ хоёр төслийн маршрут нь эхэндээ хоёулаа Монголыг тойроод явчихсан төслүүд юм. Баруун маршрут нь Чаяндины орд газраас эх авч, Сковородино, Благовещенскээр дамжин БНХАУ руу гарах “Сила Сибири” буюу “Сибирийн хүч-I” юм. Хоёр дахь нь өмнөх “Алтай” хувилбар буюу “Сибирийн хүч - II” төслийг В.Путин 2006 онд Бээжинд айлчлах үеэр анх хөндөгдөж, улмаар ажил хэрэг болсон, одоо маршрутыг нь Монголоор дайруулж өөрчлөхөөр болсон юм. Хуучин маршрут нь “Заполярье” ордоос гарсан байгалийн хийн хоолойноос “Новый Уренгой” орчмоор салаалж, улмаар Нижневартовск, Томск, Новосибирск, Барнаулаар дамжин БНХАУ-д хүрэхээр төлөвлөж байв.

2014 оноос хойш “Газпром”, Хятадын талтай Алтай чиглэлийн тухай хэлэлцсэн нь Оросоос Алтайн уулархаг бүсээр дамнан нарийн хилээр Хятадын баруун нутагт нийлүүлэх талаар байсан юм. Хятад улс өөр орноор дайруулахгүйгээр хийн хоолой барихыг илүүд үзэж байгаа боловч бусад хоолойнуудын хувьд Төв Азиас Хятадын баруун нутагт хүрч байгаа, харин Хятадын илүү хөгжсөн өмнөд хэсгийн бүс нутгуудад хийн эрэлт хамгийн их байжээ. 2014 оны 11 дүгээр сард “Газпром” болон Хятадын Үндэсний нефть-хийн корпорац хоёр дахь хийн хоолойг Алтайн чиглэлээр барих харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан боловч Орос, Хятад “Сибирийн хүч”, Арктикийн шингэрүүлсэн байгалийн хийн төслүүдэд түлхүү анхаарах болсонтой холбоотойгоор уг төсөл сүүлд зогсонги байдалд оржээ. “Алтай”-гаар дамжих төсөл нь хэд хэдэн сул талтай байв. Оросын хий нь хүн ам харьцангуй сийрэг суурьшсан Хятадын баруун нутагт хүрэх ба хийг хэрэглэгч олонтой төв ба зүүн нутаг руу дахин тээвэрлэхэд зардал гарна.

**Нэгдүгээрт**, Хятадын тал хуваарилалтын нэмэлт хоолой барихын тулд үнээ бууруулахыг “Газпром”-оос хүсэх, үүнийг нь Оросын тал зөвшөөрөх магадлал бага; **хоёрдугаарт**, Алтайн нурууны 2500 м-ийн өндөрт хоолой тавих нь техникийн хувьд маш хүндрэлтэй; **гуравдугаарт**, маршрутын дагууд газар хөдлөлтийн идэвхтэй бүс бий; **дөрөвдүгээрт**, “Алтай”-н хийн хоолой хэт урт буюу 6700 км, үүнээс 2700 км нь Оросын нутгаар дайрч өнгөрнө, **тавдугаарт**, ЮНЕСКО-гийн жагсаалтад дэлхийн өвөөр бүртгэгдсэн Укокийн дархан цаазтай газраар дайран өнгөрөх учраас экологийн хөдөлгөөнийхний ширүүн эсэргүүцэлтэй тулгарч байна. Үүний сацуу улс төрийн хувьд тогтворгүй байгаа Шинжаан-Уйгурын нутгаар хий хоолой дайрах нь эрсдэлтэй гэж үзжээ. Тухайн чиглэл нь Баруун Сибирь дэх “Газпром”-ын гол ордуудаас Хятадын хил хүртэлх хамгийн богино зайтай тул хэмнэлттэй, нийлүүлж буй хийн хэмжээг Европ болон Хятадын зах зээлүүдэд хуваарилан зохицуулах боломжтой нь давуу тал болж байв.

Хятад нь хийн эрэлт хэрэглээгээрээ дэлхийн хамгийн өсөлттэй зах зээлд тооцогдож байна. 2021 онд тус улсын цэнхэр түлшний эрэлт 335-345 тэрбум шоо метр хүрнэ гэж “Sinopet” компани тооцоолжээ. “S&P Global Platts”-ын шинжээчид 2030 онд Хятадын нийт хийн хэрэглээ 510 тэрбум шоо метр болох таамгийг дэвшүүлсэн байна. Агаарын бохирдолтой тэмцэх зорилготой Хятадын хийн хэрэгцээ жил бүр өсөх хандлагатай. Тус улс нь дамжуулах хоолойгоор Орос, Туркмени, Узбекистан, Казахстан болон Мьянмар улсаас байгалийн хий импортолж байгаа юм. 2021 оны эхний хагас жилийн дүнгээр Хятадын байгалийн хийн импорт 23 хувиар буурсныг тус улсын Гаалийн ерөнхий газар мэдээлжээ. Хятадын Үндэсний нефть-хийн корпорацийн мэдээлснээр /цар тахал дэгдэхээс өмнө/, Хятадын хийн хэрэглээ 2050 он гэхэд хоёр дахин нэмэгдэж, 15 хувьд хүрэх төлөвтэй байна. Тус компанийн тооцоогоор хийн эрэлт жилд 650 тэрбум шоо метрт хүрч нэмэгдэх, улмаар хийн хомсдол 300 тэрбум шоод хүрэх ажээ. Хятадын шинжээчид хийн хоолойг Монголын нутгаар дайруулах хувилбарт илүү эргэлзэж байгаа бөгөөд ингэснээр тээврийн эрсдэл үүсэж болзошгүй хэмээн үзэж байна. Монгол Улс АНУ-тай сайн харилцаатайгаас гадна Далай ламыг урих гэх мэт Хятадын бодлогод харш хэт үндсэрхэг байр суурийг баримталдаг тул аюулгүй байдлын хувьд эрсдэл учруулж болзошгүй гэдгийг Хятадын зарим шинжээч онцолж байгаа юм.

Сибирийн хүч-2” хэмээх шинэ төсөл нь 50 тэрбум шоо метр хүртэлх хийг Оросын Арктик дахь Ямалийн хойгоос Монголын нутгаар дайруулан барьсан 6000 километр хоолойгоор Хятадын өмнөд нутагт нийлүүлнэ. “Сибирийн хүч 2”-ын экспортыг хангах нөөцийг бэлтгэхэд ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, нийт 6700 км хоолой татахад бараг 100 тэрбум ам.долларын санхүүжилт шаардагдах ажээ. “Сибирийн хүч 1” хоолойг барьж, Чаяндинскийн ордтой холбоход зарцуулсан нийт хөрөнгө 55 тэрбум ам.доллар болсныг нээлтийн ёслолоор ОХУ-ын Эрчим хүчний сайд мэдэгдэв. Төслүүдийн үр ашигт эргэлзсэн хэвлэлүүдийн мэдээллийг няцааж “Газпром” компани албан ёсны мэдэгдэл хийж тайлбар өгөхдөө: “...Хятадын талтай “Сибирийн хүч 2” төслийн яриа хэлэлцээр үргэлжилж байгаа.

Худалдааны дайнаас үүдэн Хятад руу Америкийн шингэрүүлсэн хийн нийлүүлэлт зогсоод байгаа нөхцөл байдал нь “Сибирийн хүч 2” төсөлд Хятад түлхэц үзүүлнэ гэж харж байна. Мөн “Сибирийн хүч 1” хоолойн нийлүүлэлтийг 6 тэрбум буюу жилд 44 тэрбум шоо метр болж нэмэгдүүлэхээр Хятадын түншүүдтэй тохирсоноо Газпром” компанийн захирал А.Б.Миллер мэдэгджээ.

2019 онд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ОХУ-д айлчлах үеэр Монгол Улсын Засгийн газар, “Газпром” компани хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. “Сибирийн хүч-2” хоолой нь Оросоос байгалийн хий Хятадад нийлүүлэх хоёр дахь төсөл юм. ”Зүүн Сибирээс байгалийн хийг “Сибирийн хүч 1” хоолойгоор 2019 оны 12 сараас Хятадын зах зээлд экспортолж эхэлсэн юм. Эхний жил 4.6 тэрбум шоо метр байгалийн хий, 2021 оноос 10 тэрбум, 2022 оноос 16 тэрбум, 2024 онд 25 тэрбум, 2025 он гэхэд бүрэн хүчин чадалдаа хүрч 38 тэрбум шоо метр байгалийн хий нийлүүлнэ. 2020 оны 12 сард Орос, Хятадын төрийн тэргүүн нар ёслол төгөлдөр нээсэн “Сибирийн хүч 1” төслийн бүтээн байгуулалтад ОХУ 1.1 их наяд рублийн хөрөнгө зарцуулжээ. 15 жил үргэлжилэх энэхүү хэлэлцээрээр авсан аваагүй төлөх (take-or-pay) нөхцөлөөр тохиролцсон байдаг. Цар тахлын улмаас зах зээлийн нөхцөл байдал хүндэрснээс үүдэн хоёрдугаар улиралд Туркмени 226 ам.доллар, Узбекистан 212 ам.доллар, Казахстан 194 ам.доллараар байгалийн хийгээ Хятадад нийлүүлсэн байна. Бусад экспортлогч орнуудтай харьцуулахад Оросын байгалийн хийн үнэ 10%-иар хямдарч 183-184 ам.доллар болсон 7 сараас Оросын хийн хоолойн экспортын хэмжээ эргээд өсч эхэлжээ.

ОХУ-ын байгалийн хийг БНХАУ-д нийлүүлэх “Сибирийн хүч-2” хий дамжуулах хоолойн Монгол Улсын нутгаар дайран өнгөрөх хэсэг болох “Союз Восток” хоолойн төслийн техник-эдийн засгийн судалгааг баталсан тухай “Газпром” компани мэдэгдсэн. “Техник-эдийн засгийн судалгааны хүрээнд төслийн техник-технологийн үндсэн үзүүлэлтүүдийг боловсруулахдаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр хий дамжуулах хоолой дайран өнгөрөх чиглэл, хоолойн урт, диаметр, шахагч станцуудын тоог тооцжээ. “Союз Восток” хий дамжуулах хоолой тавих төслийн хөрөнгө оруулалт, ашиглалтын зардлын нарийвчилсан тооцоог багтаасан техник-эдийн засгийн үндэслэлийг /ТЭЗҮ/ 2021 ондоо багтаан боловсруулж дуусна гэж талууд мэдээлсэн. Монгол Улсад бүртгүүлсэн “Газопровод Союз Восток” тусгай зориулалтын “Союз Восток” хоолойн зураг төсөл, хайгуул шинжилгээ, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зорилгоор байгуулсан юм. ОХУ-ын “Газпром” компани болон Монгол Улсын Засгийн газар 2019 оны 12 сард харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хамтарсан ажлын хэсэг байгуулсан<sup>44</sup> юм. “Сибирийн хүч-2” хий дамжуулах хоолойн экспортын хүчин чадал “Сибирийн хүч-1” хий дамжуулах хоолойноос 1.3 гаруй дахин давж магадгүй. Энэ нь Оросын байгалийн хийг Баруун Сибириэс баруун төдийгүй зүүн чиглэлээр экспортлох боломжийг олгоно.

<sup>44</sup> “Газпром” Монголд байгалийн хий дамжуулах хоолойн төсөл хэрэгжүүлэх компани байгууллаа <http://eagle.mn/r/82465>

## ДҮГНЭЛТ

ОХУ-ын эрчим хүчний бодлого урт хугацааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэх геостратегийн бодлогын уламжлалд тулгуурласан, Евразийн бүс нутгийг бүхэлд нь хамарсан ОХУ-ын Евразийн үзэл санаанд тулгуурласан гадаад бодлогыг хэрэгжүүлэх дипломат ажиллагаа эрчимтэй өрнөж байна. Европ, Ази тивийг дамнасан газар зүйн байршилтай, ЗХУ-ын үед Европын улс орнуудтай холбогдсон газрын тос, байгалийн хийн эрчим хүчний цогц системээ өргөжүүлж одоо Ази руу чиглэсэн эрчим хүчний дэд бүтцийн мега төслүүдээ өргөтгөж байгаа нь уламжлалт геополитикийн бодлогын үргэлжлэл гэж үзэж болно. Геополитикийн байршлын онцгой шинж, дэлхийн эрчим хүчний зах зээлийн томоохон хэрэглэгч улс орнууд зэрэгцэн орших Ази тивд байр сууриа эзлэхийн тулд ОХУ-ын бодлогын томоохон баримт бичгүүд тасралтгүй шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа ч эрчим хүчний стратегиа өргөтгөх стратеги 2009 оноос хойш тууштай хэрэгжүүлж байна хэмээн дүгнэж байна.

Оросын стратегийн баримт бичгүүдийг авч үзэхэд Оросын бодлого боловсруулагчид тус улсын эрчим хүчний нөөцийн ач холбогдлыг гүнзгий ухамсарласан байдал ажиглагддаг. Эдгээр нөөцийг хөгжүүлэх, хамгаалах хоёр чухал шалтгаан байгаа тул улс орны үндэсний стратегийн чухал зорилт гэж үздэг. Нэгд, Оросын эрчим хүчний нөөц хүн ам, дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг боломжийн үнэтэй, найдвартай эрчим хүчээр хангадаг. Хоёрт, өнөөгийн нийгмийн тогтолцооны тогтвортой байдал, тусгаар тогтнолыг баталгаажуулж дэлхийд Оросын эдийн засгийн өрсөлдөх чадварын баталгаа гэж үздэг.

2035 он хүртэлх Оросын эрчим хүчний стратегийн ойрын жилүүдэд хэрэгжүүлэх 4 үндсэн стратегийг тодорхойлсон. Нэгдүгээрт, Оросын эрчим хүчний нөөцийн хуучин болон шинэ хэрэглэгчидтэй тогтвортой харилцаа тогтоох, хадгалах, дэлхийн эрчим хүчний зах зээлд Оросын хувьцааг баталгаажуулах; хоёрдугаарт, бүтээгдэхүүний багцын хувьд экспортын төрөлжилтийг нэмэгдүүлэх, боловсруулсан бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх; гуравдугаарт, ОХУ-ыг хийн дамжуулах хоолойн чухал тоглогч болгох; дөрөвдүгээрт, Оросын эрчим хүчний компаниуд болон тэдний гадаад түншүүдийн хамтын ажиллагааны түвшинг дээшлүүлэх хэмээн үзжээ.

Дээрх дүгнэлтүүдээс үзэхэд ОХУ-ын Ази руу чиглэсэн эрчим хүчний геополитикийн тулгуур төвүүдийг сонгохдоо уламжлалт Евразийн үзэл санаанд тулгуурласан геостратегийн нөлөөг тооцох нь дамжиггүй. ХХ зууны хоёр улсын бүтээсэн хамтын ажиллагааны уламжлал, Монгол улсын аюулгүй байдлын баталгаа болсон улсын хувьд ОХУ-тай дэд бүтцээрээ холбогдсон эрчим хүчний томоохон төслүүдийн ач холбогдол их байх нь дамжиггүй. Монгол улс байгалийн нөөц, байршлын давуу талд түшиглэн бүс нутгийн эрчим хүчний томоохон төсөлд татагдан оролцож дотоодын эдийн засгийн хязгаарлагдмал бүтцийг өөрчлөх томоохон боломж бүрдэж байна. ЗХА-ын орнуудын эрчим хүчний гол үйлдвэрлэл, хангамж байгалийн хийн хэрэглээнд тулгуурласан тул дамжуулах хоолойн дэд

бүтцээр шууд холбогдох нь ирээдүйн хийн хэрэглээ дотооддоо эрчимтэй хөгжих боломжийг бүрдүүлж байна. Улмаар Монгол улсын хувьд нүүрснээс хамааралтай дотоодын дулаан, цахилгаан үйлдвэрлэлийн системийн хязгаарлагдмал байдлыг өөрчлөх, олон төрлийн /нүүрс, газрын тос, байгалийн хий болон СЭХ г.м./ эрчим хүчний нөөц, хангамжийн дэд бүтцийг системтэйгээр төрөлжүүлэн хөгжүүлэх, эрчим хүчний бие даасан тогтолцоо бүрдүүлэх гадаад, дотоод боломж бүрдэж байгаа түүхэн таатай үеийн эхлэл тавигдаж байна хэмээн дүгнэж байна.

## НОМ ЗҮЙ

- Vladimir Kutcherov, Maria Morgunova, Valery Bessel, and Alexey Lopatin, “Russian natural gas exports: An analysis of challenges and opportunities. *Energy Strategy Reviews* 30 (2020) 100511. doi: 10.1016/j.esr.2020.100511
- Filimonova I.V., Kozhevin V.D., Nemov V.Y., Komarova A.V., and Mishenin M.V., “Supply as a factor in the destabilization of the oil market” *Energy reports* 6 (2020) 74-79.  
Doi:10.1016/j.egyр.2020.10.055
- Nicole Tryndina, Nikita Moiseev, Evgeniy Lopatin, Sergey Prosekov, and Jiang Kejun, “Trends in Corporate Energy Strategy of Russian Companies” *International Journal of Energy Economics and Policy*, 2020, 10(1), 202-207. ISSN:2146-4553 doi:10.32479/ijeeр.8644
- Filimonova I.V., Komarova A.V., Provornaya I.V., Dzyuba Y.A., and Link A.E., “Efficiency of oil companies in Russia in the context of energy and sustainable development” *Energy reports* 6 (2020) 498-504. Doi: 10.1016/j.egyр.2020.09.027
- Natalia Victorovna Kuznetsova, Ekaterina Vasilievna Kuznetsova., “Energy Strategy of the Russian Federation” *Mediterranean Journal of Social Sciences*, Vol.6, no.5 (2015), doi:10.5901/mjss.2015.v6n5p160
- Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын Гэрээ, Олон улс судлал 2019/ №1 (109)
- Стратегийн судалгаа, №71, (3/2015), Зүүн Хойд Азийн уламжлалт бус аюулгүй байдлын хамтын ажиллагаа: Улаанбаатарын яриа хэлэцээ ба АНДАБХАЗ, Сан Хюн И, 81-р тал
- Геополитик судалгааны хүрээлэн, Геополитик судлал, №1, 2015 он, Хятад, Оросын холбоотны биш боловч хөл нийлүүлсэн алхаа, 128-129-р тал
- “Турван улсын эдийн засгийн коридорыг Монгол улсын геоэдийн засгийн сонирхолтой уялдуулах нь” Бодлогын судалгааны төв. Удам соёл. 2017 он. тал 9



Vision and actions on jointly building Belt and Road, 29 March, 2015, Xinhua, April 10, 2017

Д.Уламбаяр., Геополитикийн орчны өөрчлөлт ба МУ-ын гуравдагч хөршийн бодлогын парадигм, Олон улсын харилцаа сэтгүүл, 2017№1/36, т.92

Concept of the Foreign Policy of the Russian Federation, Approved by President of the Russian Federation V. Putin, on 12 February 2013, 303-18-02-2013, IV. Regional Priorities-83, 16-р тал,

The German Marshall Fund of the United State, <http://www.gmfus.org/publications/turkey-and-russias-proxy-war-and-kurds>

Олон улсын байдал ба Монгол улс 2015 онд, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратегийн судалгааны хүрээлэн, Улаанбаатар хот, 2016 он, “ОХУ 2015 онд:

Зорилт ба Сорилт”, 7-8-р тал

Энергетическая стратегия России на период до 2035 года, проект утверждена распоряжением Правительства Российской Федерации, 56-р тал [http://www.energystrategy.ru/ab\\_ins/source/ES-2035\\_09\\_2015.pdf](http://www.energystrategy.ru/ab_ins/source/ES-2035_09_2015.pdf)

Олон улсын байдал ба Монгол улс 2015 онд, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратегийн судалгааны хүрээлэн, Улаанбаатар хот, 2016 он, “ОХУ 2015 онд: Зорилт ба Сорилт”, 28-р тал